



УУЛ УУРХАЙ, ХҮНД
ҮЙЛДВЭРИЙН ЯАМ



Schweizerische Eidgenossenschaft
Confédération suisse
Confederazione Svizzera
Confederaziun svizra

Swiss Agency for Development
and Cooperation SDC
Швейцарийн хөгжлийн агентлаг

БИЧИЛ УУРХАЙН ХОЛБОГДОЛТОЙ ХУУЛЬ, ТОГТООМЖ

(Албан ажлын хэрэгцээнд)

БИЧИЛ УУРХАЙН ХОЛБОГДОЛТОЙ **ХУУЛЬ, ТОГТООМЖ**

(Албан ажлын хэрэгцээнд)

2017 он

ГАРЧИГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

- | | |
|---|---|
| 1. Ашигт малтмалын тухай хууль
/2006 оны 7 дугаар сарын 8-ны өдөр/ | 3 |
| 2. Газрын тухай хууль
/2002 оны 6 дугаар сарын 07-ны өдөр/ | 7 |

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

- | | |
|---|----|
| 3. Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого батлах тухай
/Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого
2014-2025 он/
/2014 оны 1 дүгээр сарын 16-ны өдөр, Дугаар 18/ | 9 |
| 4. Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны
хөтөлбөр батлах тухай
/2016 оны 9 дүгээр сарын 9-ний өдөр, Дугаар 45/ | 11 |

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

- | | |
|---|----|
| 5. Журам батлах тухай
/Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам/
/2010 оны 12 дугаар сарын 1-ний өдөр, Дугаар 308/ | 14 |
| 6. "АЛТ-2" Үндэсний хөтөлбөр батлах тухай | 25 |

АШИГТ МАЛТМАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

- | | |
|--|----|
| 7. Дүрэм, заавар, маягт, гэрээний загвар батлах тухай
/2011 оны 4 дүгээр сарын 21-ний өдөр, Дугаар 153/ | 36 |
|--|----|

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2006 оны 7 дугаар

сарын 08-ны өдөр

Төрийн ордон

Улаанбаатар хот

АШИГТ МАЛТМАЛЫН ТУХАЙ (Шинэчилсэн найруулга)

3 дугаар зүйл. Хуулийн үйлчлэх хүрээ

3.1. Энэ хуулиар ус, газрын тос, байгалийн хий, цацраг идэвхт болон түгээмэл тархацтай ашигт малтмалаас бусад төрлийн ашигт малтмал эрэх, хайх, ашиглахтай холбогдсон харилцааг зохицуулна.

/Энэ хэсэгт 2009 оны 7 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

/Энэ хэсэгт 2014 оны 1 дүгээр сарын 09-ний өдрийн хуулиар нэмэлт оруулсан/

3.2. Бичил уурхайгаар ашигт малтмал олборлохтой холбогдсон харилцааг журмаар зохицуулах бөгөөд уг журмыг Засгийн газар батална.

/Энэ хэсгийг 2010 оны 7 дугаар сарын 01-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/

4 дүгээр зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

4.1. Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

4.1.23. “бичил уурхай эрхлэх” гэж үйлдвэрлэлийн аргаар ашиглахад эдийн засгийн үр ашиггүй орд, ашиглалтын болон технологийн хаягдлаар бий болсон талбайд ашигт малтмал олборлох зорилгоор Иргэний хуулийн 481.1-д заасны дагуу бүртгэгдээгүй нөхөрлөлийн, Иргэний хуулийн 35 дугаар зүйлд заасан нөхөрлөл болон 36.4-д заасан хоршооны хэлбэрээр зохион байгуулагдсан иргэдийн эрхэлж байгаа үйл ажиллагааг;

/Энэ заалтыг 2010 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн хуулиар нэмсэн/

/Энэ заалтыг 2014 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/

/Энэ заалтад 2016 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

7 дугаар зүйл. Тусгай зөвшөөрөл эзэмшигчид болон ашигт малтмал эрэх, хайх, ашиглахад тавигдах ерөнхий шаардлага

7.1. Хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийг Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу байгуулагдан үйл ажиллагаа явуулж байгаа, Монгол Улсад татвар төлөгч хуулийн этгээдэд олгоно.

7.3. Бичил уурхайгаар ашигт малтмал олборлохоос бусад тохиолдолд тусгай зөвшөөрөлгүйгээр ашигт малтмал эрэх, хайх, ашиглахыг хориглоно. Байгалийн өнгөт болон үнэт чулууг түүх, олборлох үйл ажиллагааг ердийн ашигт малтмалын адил тусгай зөвшөөрлийн үндсэн дээр эрхэлнэ.

/Энэ хэсэгт 2010 оны 7 дугаар сарын 01-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

/Энэ хэсгийг 2014 оны 7 дугаар сарын 01-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/

11 дүгээр зүйл. Төрийн захиргааны байгууллагын чиг үүрэг

11.1. Геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага (цаашид энэ хуульд “төрийн захиргааны байгууллага” гэх) дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:

11.1.13. улсын төсвийн хөрөнгөөр илрүүлсэн эрдсийн хуримтлал бүхий талбайд тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалт зохион явуулах, бичил уурхайн болон түгээмэл тархацтай ашигт малтмалын зориулалтаар талбай олгох дүгнэлт гаргах;

/Энэ заалтад 2014 оны 7 дугаар сарын 01-ний өдрийн хуулиар нэмэлт оруулсан/

11.1.23. энэ хуулийн 12.1.5-д заасны дагуу сум, дүүргийн Засаг даргын гаргасан хүсэлтийг хүлээн авч сонгосон газар нь ашигт малтмал эрэх, хайх, ашиглахыг хязгаарласан буюу хориглосон, эсхүл тусгай хэрэгцээ, нөөцөд авсан, түүнчлэн хүчин төгөлдөр тусгай зөвшөөрлөөр нэгэнт олгогдсон талбайтай бүхэлдээ буюу хэсэгчлэн давхацсан эсэх талаар дүгнэлт гаргаж, газрын хэмжээ, хил хязгаарыг тогтоох;

/Энэ заалтыг 2010 оны 7 дугаар сарын 01-ний өдрийн хуулиар нэмсэн/

11.2. Төрийн захиргааны байгууллагын геологийн асуудал хариуцсан нэгж нь энэ зүйлийн 11.1.1 – 11.1.7, уул уурхайн асуудал хариуцсан нэгж нь энэ зүйлийн 11.1.8 – 11.1.12, кадастрын асуудал хариуцсан нэгж нь энэ зүйлийн 11.1.13 – 11.1.23-т заасан асуудлыг эрхэлнэ.

/Энэ хэсэгт 2010 оны 7 дугаар сарын 01-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

11.3. Ашигт малтмалын тухай хууль тогтоомжийн хэрэгжилт болон цацраг идэвхт ашигт малтмалаас бусад төрлийн ашигт малтмал эрэх, хайх, ашиглах үйл ажиллагаанд тавих улсын хяналтыг мэргэжлийн хяналтын байгууллага гүйцэтгэнэ.

/Энэ хэсэгт 2009 оны 7 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан/

12 дугаар зүйл. Нутгийн захиргааны болон өөрөө удирдах байгууллагын бүрэн эрх

12.1. Ашигт малтмалын асуудлаар нутгийн захиргааны болон өөрөө удирдах байгууллага дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

12.1.1. ашигт малтмалын тухай хууль тогтоомж, түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан Засгийн газраас гаргасан шийдвэрийн биелэлтийг харьяалах нутаг дэвсгэртээ зохион байгуулах;

12.1.4. газрын тухай хуульд заасан үндэслэл, журмын дагуу тодорхой газрыг орон нутгийн тусгай хэрэгцээнд авах шийдвэр гаргах;

12.1.5. газрын тухай хуулийн 16.1.11-д заасан зориулалтаар олгохоор сонгосон газрын талаар энэ хуулийн 11.1.23-д заасан дүгнэлт гаргуулах тухай хүсэлтийг төрийн захиргааны байгууллагад тавьж шийдвэрлүүлэх.

/Энэ заалтыг 2010 оны 7 дугаар сарын 01-ний өдрийн хуулиар нэмсэн/

35 дугаар зүйл. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нийтлэг үүрэг

35.6. Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээд, бичил уурхайгаас алт олборлогч нь олборлосон алтаа тухайн санхүүгийн жилдээ багтааж тушаана.

/Энэ хэсгийг 2014 оны 1 дүгээр сарын 24-ний өдрийн хуулиар нэмсэн/

47 дугаар зүйл. Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр

47.3. Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр дараахь хэмжээтэй байна:

47.3.1. дотоодод борлуулж байгаа нүүрсний нөөц ашигласны төлбөр тухайн уурхайн эдэлбэрээс олборлож худалдсан, эсхүл худалдахаар ачуулсан болон ашигласан бүтээгдэхүүний борлуулалтын үнэлгээний 2,5 хувьтай тэнцүү;

/Энэ заалтад 2011 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

47.3.2. энэ хуулийн 47.3.1, 47.3.3-т заасан Монголбанк, түүнээс эрх олгосон банкинд худалдсан алтнаас бусад ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн доод хэмжээ нь тухайн уурхайн эдэлбэрээс олборлож худалдсан, эсхүл худалдахаар ачуулсан болон ашигласан бүтээгдэхүүний борлуулалтын үнэлгээний 5,0 хувьтай тэнцүү.

/Энэ заалтад 2010 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

/Энэ заалтад 2014 оны 1 дүгээр сарын 24-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

47.3.3. Монголбанк, түүнээс эрх олгосон банкинд худалдсан алтанд энэ хуулийн 47.3.2-т заасан ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн хэмжээ 2,5 хувь, энэ хуулийн 47.5-д заасан нэмэлт төлбөрийн хэмжээ 0 хувьтай тэнцүү.

/Энэ заалтыг 2014 оны 1 дүгээр сарын 24-ний өдрийн хуулиар нэмсэн бөгөөд энэ заалтыг 2014 оны 1 дүгээр сарын 24-ний өдрөөс эхлэн 2019 оны 1 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэл хугацаанд дагаж мөрдөнө/

66 дугаар зүйл. Хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага

66.1. Ашигт малтмалын тухай хууль тогтоомж зөрчсөн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол эрх бүхий улсын байцаагч зөрчлийн шинж байдлыг харгалзан гэм буруутай этгээдэд дараахь хариуцлага хүлээлгэнэ:

66.1.9. бичил уурхайгаар ашигт малтмал олборлохтой холбогдсон харилцааг зохицуулах журмыг зөрчсөн иргэнийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас арав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний, албан тушаалтныг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг арваас хорь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний, хуулийн этгээдийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг гучаас дөч дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох.

/Энэ заалтыг 2010 оны 7 дугаар сарын 01-ний өдрийн хуулиар нэмсэн/

/Энэ заалтад 2014 оны 7 дугаар сарын 01-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2002 оны 6 дугаар сарын
07-ны өдөр

Улаанбаатар хот

ГАЗРЫН ТУХАЙ /Шинэчилсэн найруулга/

16 дугаар зүйл. Тусгай хэрэгцээний газар

16.1. Монгол Улс тусгай хэрэгцээний газартай байна. Улсын тусгай хэрэгцээний газарт дараахь газар хамаарна:

16.1.1. улсын тусгай хамгаалалттай газар;

16.1.2. улсын хилийн зурвас газар;

16.1.3. улсын батлан хамгаалах болон аюулгүй байдлыг хангах зориулалтаар олгосон газар;

16.1.4. гадаад улсын дипломат төлөөлөгчийн болон консулын газар, олон улсын байгууллагын төлөөлөгчийн газарт олгосон газар;

16.1.5. шинжлэх ухаан, технологийн сорилт, туршилт болон байгаль орчин, цаг агаарын төлөв байдлын байнгын ажиглалтын талбай;

16.1.6. аймаг дундын отрын бэлчээр;

16.1.7. улсын тэжээлийн сангийн хадлангийн талбай.

16.1.8. бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу хайгуулын зориулалтаар ашиглах газрын тосны гэрээт талбай;

16.1.9. чөлөөт бүсийн газар.

16.1.10. цөмийн төхөөрөмж барих, ашиглах зориулалтаар олгосон газар.

/Энэ заалтыг 2009 оны 7 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар нэмсэн/

16.1.11. бичил уурхайн зориулалтаар олгосон газар.

/Энэ заалтыг 2010 оны 7 дугаар сарын 01-ний өдрийн хуулиар нэмсэн/

16.1.12. хилийн боомтын бүс.

/Энэ заалтыг 2013 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн хуулиар нэмсэн/

16.2. Аймаг, нийслэл, сум, дүүрэг энэ хуулийн 16.1.1, 16.1.6, 16.1.7, 16.1.11-д заасан зориулалтаар өөрийн эрх хэмжээнд нийцүүлэн газрыг орон нутгийн тусгай хэрэгцээнд авч болно.

/Энэ хэсэгт 2010 оны 7 дугаар сарын 01-ний өдрийн хуулиар нэмэлт оруулсан/

16.3. Газрын нэгдмэл сангийн аль ч ангиллын газраас тусгай хэрэгцээнд авч болно.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2014 оны 1 дүгээр сарын
16 өдөр

Төрийн ордон,
Улаанбаатар хот

Дугаар 18

Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого батлах тухай

Ашигт малтмалын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалт, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. “Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого”-ыг хавсралтаар баталсугай.

2. “Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого”-ыг баталсантай холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Н.Алтанхуяг/-т даалгасугай:

1/ “Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого”-ын зарчим, зорилтод нийцүүлэн эрдэс баялгийн салбарын холбогдох хууль тогтоомжийн төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлж, батлуулан хэрэгжүүлэх;

2/ “Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого”-д тусгасан зорилт, чиглэлийг Монгол Улсын жил бүрийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, улсын төсөв, төрийн мөнгөний бодлого, дунд, урт хугацааны төлөвлөлтөд тусгуулан хэрэгжүүлэх.

3. “Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого”-ын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороо /Б.Гарамгайбаатар/-нд үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА З.ЭНХБОЛД

Монгол Улсын Их Хурлын 2014
оны 18 дугаар тогтоолын хавсралт

**ТӨРӨӨС ЭРДЭС БАЯЛГИЙН САЛБАРТ
БАРИМТЛАХ БОДЛОГО**
/2014-2025 он/

Гурав. Эрдэс баялгийн салбарт баримтлах бодлогын чиглэл

3.1. Эрдэс баялгийн салбарын эрх зүйн орчныг боловсронгуй болгох хүрээнд:

3.1.2. бичил уурхайгаар ашигт малтмал олборлогч иргэдийг хууль ёсны бүтцээр хоршиж ажиллах чиглэлийг төрөөс бодлогоор дэмжиж, холбогдох эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох;

---oOo---

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2016 оны 9 дүгээр сарын
09-ний өдөр

Улаанбаатар хот

Дугаар 45

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 2016-2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР БАТЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 7 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. “Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийг хавсралтаар баталсугай.

2. Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлагдсантай холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Ж.Эрдэнэбат/-т даалгасугай:

1/Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний нарийвчилсан төлөвлөгөөг баталж, хөтөлбөрийн биелэлтийг жил бүрийн 1 дүгээр улиралд багтаан Монгол Улсын Их Хуралд танилцуулж байх;

2/Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт дэвшүүлсэн зорилтыг жил бүрийн төсвийн хүрээний мэдэгдэл, эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, улсын төсөвт тусган хэрэгжүүлэх;

3. Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх чиглэлээр Засгийн газартай үйл ажиллагаагаа уялдуулан хамтран ажиллахыг Монголбанкны Ерөнхийлөгч, Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг холбогдох бусад байгууллагын дарга нарт үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

М.ЭНХБОЛД

*Монгол Улсын Их Хурлын 2016 оны
45 дугаар тогтоолын хавсралт*

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 2016–2020 ОНЫ
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР**

**ХОЁР.ЭДИЙН ЗАСГИЙН ТОГТВОРТОЙ ӨСӨЛТИЙГ
ХАНГАХ БОДЛОГО**

Геологи, уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарын хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээ:

Геологи, уул уурхайн салбарын хөрөнгө оруулалтын таатай орчинг бүрдүүлэх, уул уурхайн салбарын тогтвортой хөгжлийг хангах, олон улсын эрдсийн зах зээл дэх Монгол Улсын өрсөлдөх чадварыг дээшлүүлнэ.

2.59.Монгол орны геологийн зураглал, ерөнхий эрэл, агаарын геофизик, геохими, гидрогеологи, геоэкологийн судалгааны ажлын хэмжээг нэмэгдүүлэх замаар уул уурхайн салбарын тогтвортой хөгжлийг дэмжинэ.

2.60.Олон улсын жишгийн дагуу Үндэсний геологийн алба, Үндэсний геомэдээллийн санг байгуулан, мэдээлэл түгээх үйлчилгээг хялбаршуулна.

2.61.Геологи, уул уурхайн салбарт хөрөнгө оруулалтыг татах эрх зүйн таатай орчинг бүрдүүлж, харилцан үр ашигтай төсөл, хөтөлбөрийг хамтран хэрэгжүүлнэ.

2.62.Уул уурхайн үйлдвэрлэл дэх төрийн оролцоог зохистой хэмжээнд байлгаж, Кадастрын бүртгэлийн системийг боловсронгуй болгож, тусгай зөвшөөрөл олгох үйлчилгээг хөнгөн шуурхай болгоно.

2.63.Газрын тосны болон уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул, ашиглалтын ажлыг эрчимжүүлж, нөөцийг өсгөнө.

2.64.“Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого”-ын 3.1.2-т заасан иргэд бичил уурхайн салбарт хууль ёсны бүтцээр

хоршиж ажиллах чиглэлийг хэрэгжүүлэн холбогдох эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгоно.

2.65. Уул уурхайн дэд бүтцийн хөгжлийн урт хугацааны төлөвлөлт боловсруулж, салбар хоорондын уялдааг сайжруулна.

2.66. Уул уурхайн судалгааны нэгж байгуулж, эрдэс баялгийн салбарт хөрөнгө оруулалтын таатай орчинг бий болгоно.

2.67. Хоёрдогч ашигт малтмал ашиглах эрх зүйн орчинг бий болгож, уурхайн нөхөн сэргээлт, хаалтыг олон улсын жишигт хүргэнэ.

2.68. "Алт-2" хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилтийг Монголбанкттай хамтран шийдвэрлэнэ.

2.69. Алтны олборлолтыг нэмэгдүүлж, бичил уурхай эрхлэгчдийн олборлосон алтыг худалдан авах эрх зүйн орчинг бүрдүүлнэ.

2.70. Газрын тосны олборлолтыг тогтвортой нэмэгдүүлэн, газрын тос боловсруулах үйлдвэр байгуулна.

2.71. Зэсийн баяжмал хайлуулах, цэвэршүүлэх үйлдвэр байгуулах ажлыг дэмжиж ажиллана.

2.72. Дархан, Сэлэнгийн бүсэд хар төмөрлөгийн цогцолбор байгуулах нөхцөлийг бүрдүүлнэ.

2.73. Нүүрс угаах, гүн боловсруулах үйлдвэр болон нүүрсний нийлэг хийн үйлдвэр байгуулахыг бодлогоор дэмжинэ.

2.74. Шингэрүүлсэн түлш, шатах тослох материалын үйлдвэр байгуулах ажлыг бодлогоор дэмжинэ.

2.75. Метал хийц, угсралтын үйлдвэрийг хөгжүүлнэ.



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2010 оны 12 дугаар
сарын 1-ний өдөр

Улаанбаатар хот

Дугаар 308

Журам батлах тухай

Ашигт малтмалын тухай хуулийн 3.2-т заасныг үндэслэн
Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам”-ыг
хавсралт ёсоор баталсугай.

2. Энэ журмыг хэрэгжүүлэх талаар зохион байгуулалтын
болон зохицуулалтын арга хэмжээ авахыг Эрдэс баялаг, эрчим
хүчний сайд Д.Зоригтод, журмын хэрэгжилтэд тогтмол хяналт
тавьж байхыг Мэргэжлийн хяналтын ерөнхий газарт, журмыг
хэрэгжүүлэх ажлыг нутаг дэвсгэртээ зохион байгуулж ажиллахыг
аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

3. Энэхүү журам батлагдсантай холбогдуулан “Түр журам
батлах тухай” Засгийн газрын 2008 оны 2 дугаар сарын 27-ны өдрийн
72 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

Монгол Улсын Ерөнхий сайд

С.БАТБОЛД

Эрдэс баялаг, эрчим хүчний сайд

Д.ЗОРИГТ

Монгол Улсын Засгийн газрын 2010 оны
308 дугаар тогтоолын хавсралт

БИЧИЛ УУРХАЙГААР АШИГТ МАЛТМАЛ ОЛБОРЛОХ ЖУРАМ

Нэг. Ерөнхий зүйл

1.1. Бичил уурхайн хэлбэрээр ашигт малтмал олборлох үйл ажиллагааг энэхүү журмаар зохицуулна.

1.2. Энэхүү журам нь ус, цацраг идэвхт элемент агуулсан хүдэр, газрын тос, байгалийн хийгээс бусад төрлийн ашигт малтмалыг бичил уурхайн хэлбэрээр олборлох үйл ажиллагаанд хамаарна.

Хоёр. Бичил уурхайн талаархи сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын эрх, үүрэг

Сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь дараахь эрх, үүрэгтэй байна:

2.1. Бичил уурхайн хэлбэрээр ашигт малтмал олборлох талаар нөхөрлөлөөс гаргасан хүсэлтийг хүлээн авч Газрын тухай хуулийн 16.1.11-д заасан зориулалтаар орон нутгийн тусгай хэрэгцээнд авах газрыг сонгож, солбицлыг тогтоох.

2.2. Бичил уурхайн зориулалтаар орон нутгийн тусгай хэрэгцээнд авахаар сонгож, солбицлыг тогтоосон газрын талаар Ашигт малтмалын тухай хуулийн 11.1.23-т заасан дүгнэлт гаргуулахаар геологи, уул уурхайн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүсэлт тавихыг зөвшөөрсөн шийдвэр гаргах.

2.3. Сонгосон газрыг бичил уурхайн зориулалтаар ашиглах боломжгүй болох нь геологи, уул уурхайн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын гаргасан дүгнэлтээр тогтоогдвол тухайн сум, дүүргийн нутагт бичил уурхайгаар ашиглах бололцоогүй болсон тухай шийдвэрийг ажлын 10 хоногт багтаан гаргах.

2.4. Сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал гаргасан шийдвэрээ иргэдэд зарлан мэдэгдэж, хэрэгжилтэд нь хяналт тавих.

Гурав. Бичил уурхайн талаархи сум, дүүргийн Засаг даргын эрх, үүрэг

Сум, дүүргийн Засаг дарга дараахь эрх, үүрэгтэй байна:

3.1. Сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрийн дагуу бичил уурхайгаар ашигт малтмал олборлох иргэдэд бүртгэгдээгүй нөхөрлөлийн зохион байгуулалтад ороход нь эрх зүйн туслалцаа, дэмжлэг үзүүлж энэ талаар үнэ төлбөргүй зөвлөгөө өгөх.

3.2. Сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын бичил уурхайн зориулалтаар сонгож шийдвэрлэсэн газрын талаар дүгнэлт гаргуулахаар энэхүү журмын 2.2-т заасан хүсэлтийг геологи, уул уурхайн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлж шийдвэрлүүлэх ажлыг зохион байгуулах.

3.3. Геологи, уул уурхайн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас бичил уурхайн зориулалтаар ашиглаж болох тухай дүгнэлт гарсан тохиолдолд сум, дүүргийн Засаг дарга нь сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын энэхүү журмын 2.2-т заасан шийдвэрийг үндэслэн өргөдөл гаргасан нөхөрлөлтэй бичил уурхайгаар ашигт малтмал олборлох тухай гэрээг нэг жилийн хугацаагаар байгуулна. Нөхөрлөлөөс гаргасан хүсэлтийн дагуу гэрээний хугацааг нэг нэг жилээр сунгаж болно .

3.4. Сум, дүүргийн хэмжээнд бичил уурхайн зориулалтаар олгосон газрын зураг зүйн нэгдсэн бүртгэл, олборлолтын мэдээг хөтлөх.

3.5. Бичил уурхай эрхлэгчдэд эрүүл мэндийн болон нийгмийн халамжийн үйлчилгээ үзүүлэх, хүүхдийг нь сургууль, цэцэрлэгт хамруулах арга хэмжээ авах.

3.6. Бичил уурхай эрхлэгчдийг татвар, даатгалд хамруулах ажлыг удирдлага, зохицуулалтаар хангах.

3.7. Байгаль орчныг нөхөн сэргээх талаар нөхөрлөлөөс авсан арга хэмжээ, хийсэн ажлын тайланг авч, газар дээр нь шалган, геологи,

уул уурхайн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас баталсан зааврын дагуу нөхөн сэргээлтийн ажлыг хийлгэсний үндсэн дээр хүлээн авч, энэ тухай мэдээллийг аймаг, нийслэлийн мэргэжлийн хяналтын байгууллагад жилд 1 удаа хүргүүлж байх.

3.8. Нөхөрлөл болон сум, дүүргийн нутгийн захиргааны байгууллага нь нөхөрлөлийн олборлолт явуулсан талбайд хийгдэх техникийн болон биологийн нөхөн сэргээлтийн ажлын зардлыг тооцож, зохих мөнгөн хөрөнгийг нөхөн сэргээлтийн дундын санд төвлөрүүлэх ажлыг зохион байгуулж, тухайн нөхөрлөлтэй хамтран захиран зарцуулах.

3.9. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль тогтоомж болон геологи, уул уурхайн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас баталсан бичил уурхайн хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны дүрмийг мөрдүүлэх.

3.10. Бичил уурхай эрхлэгчдийн үйл ажиллагааны талаархи мэдээллийг батлагдсан маягтын дагуу гаргаж, геологи, уул уурхайн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад жил бүрийн 2 дугаар сарын 15-ны дотор хүргүүлж байх.

3.11. Энэ журмын 10.2-т заасны дагуу нөхөн сэргээлт хийгээгүй нөхөрлөл болон тус нөхөрлөлийн гишүүдийн шинээр үүсгэн байгуулсан нөхөрлөлтэй ашигт малтмал олборлох гэрээ дахин байгуулахгүй байх.

3.12. Нөхөрлөлийн буруутай үйл ажиллагааны улмаас байгаль орчинд сөрөг нөлөөлөл учирсан болох нь мэргэжлийн байгууллагаас тогтоогдсон тохиолдолд тухайн нөхөрлөлтэй байгуулсан ашигт малтмал олборлох гэрээг цуцлах.

3.13. Нөхөрлөлийн олборлолт явуулж байгаа газрын нутаг дэвсгэрт уурхайчид болон тэдгээрийн гэр бүлийн гишүүдийн амьдрах суурьшлын бүсийг тогтоож, хүрээлэн байгаа орчныг бохирдлоос хамгаалах, хог хаягдлын асуудлыг шийдвэрлэх ажлыг нэгдсэн удирдлагаар хангах.

Дөрөв. Бичил уурхайн талаар геологи, уул уурхайн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын эрх, үүрэг

Геологи, уул уурхайн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь дараахь эрх, үүрэгтэй байна:

4.1. Ашигт малтмалын тухай хуулийн 11.1.23, энэ журмын 3.2-т заасан хүсэлтийн дагуу бичил уурхайгаар ашигт малтмал олборлоход зориулан сонгосон газрын талаархи дүгнэлтийг кадастрын зураг зүйн бүртгэл, мэдээлэлд тулгуурлан, ажлын 14-21 хоногт гаргаж сум, дүүргийн Засаг даргад хүргүүлэх.

4.2. Бичил уурхайгаар ашигт малтмал олборлохыг зөвшөөрсөн тухай дүгнэлт гаргасан газрыг кадастрын зураг зүйн нэгдсэн бүртгэлд бүртгэх.

4.3. Дараахь дүрэм, заавар, маягт, загварыг батлах:

4.3.1. ашигт малтмал олборлох гэрээ байгуулах талаар сум, дүүргийн Засаг даргад нөхөрлөлөөс гаргах өргөдлийн маягт;

4.3.2. бичил уурхайгаар ашигт малтмал олборлох талаар сум, дүүргийн Засаг дарга, нөхөрлөлийн хооронд байгуулах гэрээний үлгэрчилсэн загвар;

4.3.3. бичил уурхайгаар ашигт малтмал олборлох талаар сум, дүүргийн Засаг дарга, ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч, нөхөрлөлийн хооронд байгуулах гурвалсан гэрээний үлгэрчилсэн загвар, энэхүү гэрээний үлгэрчилсэн загварт дараахь асуудлыг тодорхой тусгана:

4.3.3.1. ашигт малтмал олборлох, борлуулах;

4.3.3.2. байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх;

4.3.3.3. хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй;

4.3.3.4. гэрээгээр ашиглуулах талбай.

4.3.4. бичил уурхайн талбайд байгаль орчны нөхөн сэргээлт хийх заавар;

4.3.5. хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны дүрэм;

4.3.6. бичил уурхай эрхлэгчдийн үйл ажиллагааны талаархи мэдээллийн маягт.

4.4. Нөхөрлөлийн гишүүдэд байгаль орчны болон хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны талаар чадваржуулах сургалт явуулж, дэмжлэг үзүүлэх.

Тав. Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох газар

5.1. Бичил уурхайн зориулалтаар нөхөрлөлд эзэмшүүлэх газрын хэмжээ 5 га-гаас ихгүй байна.

5.2. Нэг сум, дүүргийн нутаг дэвсгэрт бичил уурхайн хэлбэрээр ашигт малтмал олборлоход зориулан сонгосон газрын тоо 10-аас илүүгүй байна.

5.3. Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох зориулалтаар ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн уурхайн эдэлбэр газраас сум, дүүргийн Засаг дарга, тусгай зөвшөөрөл эзэмшигч, нөхөрлөлийн хооронд байгуулсан гурвалсан гэрээний дагуу нөхөрлөлд талбай ашиглуулж болно.

5.4. Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн уурхайн эдэлбэр газраас бичил уурхайгаар ашигт малтмал олборлох нөхцөлд нэг сум, дүүргийн нутаг дэвсгэрт бичил уурхайн хэлбэрээр ашигт малтмал олборлоход зориулсан газрын тоо 10-аас илүү байж болно.

5.5. Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн уурхайн эдэлбэр газраас сум, дүүргийн Засаг дарга, тусгай зөвшөөрөл эзэмшигч, нөхөрлөлийн хооронд гурвалсан гэрээ байгуулсны үндсэн дээр нөхөрлөлд далд уурхай ашиглуулж болно.

5.6. Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь энэхүү журмын 5.3, 5.5-д заасны дагуу уурхайн эдэлбэр газраас нөхөрлөлд талбай ашиглуулсан нь Ашигт малтмалын тухай хуулийн 39 дүгээр зүйлд заасан байгаль орчныг хамгаалах талаар ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хүлээх үүргээс чөлөөлөгдөх үндэслэл болохгүй.

Зургаа. Ашигт малтмал олборлох иргэдийн зохион байгуулалт

6.1. Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох иргэд нь Иргэний хуулийн 476 дугаар зүйлд заасны дагуу хамтран ажиллах гэрээг бичгээр байгуулж, мөн хуулийн 481.1 дүгээр зүйлд заасан бүртгэгдээгүй нөхөрлөлийн хэлбэрээр зохион байгуулагдсан байна.

6.2. Нөхөрлөлийн үйл ажиллагаа нь Иргэний хуулийн 477-482 дугаар зүйл болон нөхөрлөлийн дүрмийн дагуу зохицуулагдана.

6.3. Нөхөрлөл нь оноосон нэртэй байна. Нэг сум, дүүргийн нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа эрхэлж байгаа нөхөрлөл нь өөр нөхөрлөлтэй давхардсан нэртэй байж болохгүй.

6.4. Нөхөрлөлийн гишүүдийн тоо нь 5-аас цөөнгүй байна.

6.5. Нөхөрлөлийн гишүүн өөр нөхөрлөлийн гишүүн байхыг хориглоно.

Долоо. Ашигт малтмал олборлох гэрээ байгуулах тухай өргөдөл гаргах

7.1. Нөхөрлөл Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох гэрээ байгуулах тухай өргөдлөө сум, дүүргийн Засаг даргад энэхүү журмын 4.3.1-д заасан маягтын дагуу бичгээр гаргана.

7.2. Өргөдөлд дараахь зүйлийг заавал тусгана:

7.2.1. нөхөрлөлийн нэр, нөхөрлөлийн ахлагч буюу эрх бүхий төлөөлөгч болон гишүүдийн нэр, хаяг;

7.2.2. талбайн байршил;

7.2.3. олборлох ашигт малтмалын төрөл.

7.3. Өргөдөлд дараахь баримт бичгийг хавсаргана:

7.3.1. нөхөрлөлийн гишүүдийн иргэний үнэмлэхийн хуулбар;

7.3.2. нөхөрлөлийн гишүүдийн хооронд бичгээр байгуулсан хамтран ажиллах гэрээний хуулбар;

7.3.3. олборлолт явуулах талбайн байршлын зураг;

7.3.4. нөхөрлөлийн гишүүний албан татвар төлөгчийн гэрчилгээ, дэвтрийн хуулбар;

7.3.5. нөхөрлөлийн гишүүдийн эрүүл мэнд, нийгмийн даатгалын дэвтрийн хуулбар.

7.4. Нөхөрлөлийн гишүүдэд дараахь шаардлага тавигдана:

7.4.1. Монгол Улсын иргэн байх;

7.4.2. 18 нас хүрсэн байх;

7.4.3. тухайн орон нутагт оршин суугчаар бүртгүүлсэн байх.

7.5. Энэхүү журмын 7.1-7.4-т заасан шаардлага хангаагүй өргөдлийг хүлээн авахгүй.

7.6. Нөхөрлөл олборлолт явуулсан талбайг энэхүү журмын 10.2-т заасан шаардлагын дагуу хүлээлгэн өгсний дараа өөр газарт ашигт малтмал олборлох гэрээ байгуулах тухай өргөдлийг тухайн сум, дүүргийн Засаг даргад гаргаж болно.

7.7. Сум, дүүргийн Засаг дарга өргөдлийг хүлээн авснаас хойш ажлын 10 хоногт багтаан дараахь шаардлагыг хангасан эсэхийг тодруулна:

7.7.1. энэхүү журмын 7.4-т заасан шаардлагыг хангасан эсэх;

7.7.2. энэхүү журмын 7.3-т заасан баримт бичгийг бүрдүүлсэн эсэх;

7.7.3. өргөдөлд заасан талбай нь энэхүү журмын 5.1-д заасан газрын хязгаарт багтаж байгаа эсэх;

7.7.4. тухайн нөхөрлөл өмнө нь олборлолт явуулж байсан бол байгаль орчны техникийн болон биологийн нөхөн сэргээлтийг энэ журмын 10.2-т заасны дагуу бүрэн хийсэн эсэх.

7.8. Өргөдөл, хавсаргасан баримт бичиг энэхүү журмын 7.7-д заасан шаардлагыг хангасан тохиолдолд өргөдлийн бүртгэгдсэн дарааллын дагуу Ашигт малтмал олборлох гэрээ байгуулна.

Найм. Ашигт малтмал олборлох гэрээ байгуулах

8.1. Энэхүү журмын 5.1-д заасан газарт ашигт малтмал олборлох нөхөрлөл нь тухайн сум, дүүргийн Засаг даргатай бичгээр гэрээ байгуулна.

8.2. Гэрээнд дараахь асуудлыг тусгана:

8.2.1. талуудын эрх, үүрэг, хариуцлага;

8.2.2. талбайн байршил, хэмжээ;

8.2.3. гэрээний хугацаа, түүнийг сунгах нөхцөл;

8.2.4. энэхүү журмын 5.1-д заасан газрыг ашиглуулах нөхцөл;

8.2.5. байгаль орчныг нөхөн сэргээх чиглэлээр хийх ажлын төлөвлөгөө, төсөв, зардлын эх үүсвэрийн баталгаа;

8.2.6. олборлох ашигт малтмалын төрөл;

8.2.7. бичил уурхайн хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны дүрэм, заавар, эрүүл ахуйн норм, стандартыг мөрдөх нөхцөл;

8.2.8. нөхөрлөлийн гишүүдийг нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалд хамруулах нөхцөл;

8.2.9. химийн хорт болон аюултай бодис ашиглахгүй байх тухай үүрэг;

8.2.10. тэсэрч, дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг ашиг-лахдаа зөвхөн тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээдээр хийлгэх үүрэг;

8.2.11. гэрээг цуцлах болон дуусгавар болох үндэслэл;

8.2.12. хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны дүрмийг зөрчсөнөөс үүсэн гарах хариуцлага;

8.2.13. талбайн байгаль орчныг хамгаалах, хог хаягдлын цэг байгуулах, нөхөрлөлийн гишүүд, тэдгээрийн гэр бүлийн гишүүдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх, тогтоосон суурьшлын бүсэд амьдрах талаархи үүрэг;

8.2.14. бусад зүйл.

Ес. Нөхөрлөлийн олборлосон ашигт малтмалыг борлуулах

9.1. Нөхөрлөлийн олборлосон ашигт малтмалыг холбогдох хууль тогтоомжийн дагуу худалдах, худалдан авах эрх бүхий хуулийн этгээдэд худалдана.

Арав.Талбайг буцааж хүлээлгэн өгөх

10.1. Нөхөрлөл дараахь нөхцөлд талбайг буцааж хүлээлгэн өгнө:

10.1.1. ашигт малтмалын нөөц эдийн засгийн хувьд ашиггүй гэж үзсэн;

10.1.2. хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн нөхцөлөөс шалтгаалан олборлолтыг үргэлжлүүлэх боломжгүй болсон тухай улсын байцаагчийн дүгнэлт гарсан;

10.1.3. нөхөрлөл талбайг хүлээлгэн өгөх хүсэлт гаргасан;

10.1.4. нөхөрлөлтэй байгуулсан гэрээг цуцалсан;

10.1.5. нөхөрлөлтэй байгуулсан гэрээг хугацаанаас нь өмнө цуцалсан нь тухайн нөхөрлөлийг олборлолт хийсэн талбайдаа техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх үүргээс чөлөөлөхгүй.

10.2. Нөхөрлөл талбайг буцааж хүлээлгэн өгөхийн өмнө тухайн талбайд техникийн болон биологийн нөхөн сэргээлтийн ажлыг зааврын дагуу хийж, байгаль орчны хяналтын улсын байцаагчийн дүгнэлт гаргуулан, сум, дүүргийн Засаг даргын томилсон комисст хүлээлгэн өгнө. Урьд нь том уурхайн олборлолт явуулаад нөхөн сэргээлт хийгээгүй газарт олборлолт явуулж байгаа тохиолдолд зөвхөн нөхөрлөлийн олборлолт хийсэн газарт нөхөн сэргээлтийг зааврын дагуу хийнэ.

10.3. Нөхөрлөл болон нутгийн захиргааны байгууллага нь нөхөн сэргээлтийн дундын сангийн мөнгөн хөрөнгийг зөвхөн энэхүү журмын 10.2-т заасан зориулалтаар хамтран захиран зарцуулна.

Арван нэг. Бичил уурхайгаар ашигт малтмал олборлоход хориглох зүйл

11.1. Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох үйл ажиллагаанд дараахь зүйлийг хориглоно:

11.1.1. 18 нас хүрээгүй иргэнийг ажиллуулах;

11.1.2. хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн дүрэм зөрчих;

11.1.3. гэрээгээр олгосон газраас бусад газарт ашигт малтмал агуулсан шороо, хүдрийг угааж баяжуулах;

11.1.4. албан татвар төлөхөөс зайлсхийх;

11.1.5. нөхөрлөлийн гишүүн бус этгээдийг оролцуулах;

11.1.6. химийн хорт болон аюултай бодис ашиглах;

11.1.7. тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээдээр гүйцэтгүүлэхээс бусад тохиолдолд тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл ашиглах;

11.1.8. нөхөрлөлд гэрээгээр олгосон талбайг зориулалт бусаар ашиглах, бусдад шилжүүлэх, барьцаалах, худалдах;

11.1.9. байгаль орчинд ноцтой сөрөг нөлөө үзүүлэх;

11.1.10. ашигт малтмал олборлолтын үйл ажиллагаанд 500 см³-ээс дээш багтаамжтай дотоод шаталтат хөдөлгүүр бүхий механизмыг ашиглах;

11.1.11. энэ журмын 5.3-т заасан гурвалсан гэрээг байгуулахгүйгээр ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн талбайд зэрэгцэн үйл ажиллагаа явуулах;

11.1.12. энэ журмын 5.5-д заасан гурвалсан гэрээ байгуулахгүйгээр дангаараа далд уурхай ашиглах.

Арван хоёр. Онцгой нөхцөл

12.1. Нөхөрлөлийн алтны үндсэн ордоос олборлосон хүдрийг баяжуулах үйл ажиллагааг явуулах газрын байршлыг геологи, уул уурхайн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, аймаг, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, мэргэжлийн хяналтын байгууллага хамтран тогтооно.

12.2. Баяжуулах цехэд тавигдах техникийн нөхцөлийг геологи, уул уурхайн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага боловсруулна.

12.3. Тогтоосон газарт баяжуулах цехэд тавигдах техникийн нөхцөлийн шаардлага хангасан аж ахуйн нэгжийг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал сонгон шалгаруулна.

12.4. Цехийг геологи, уул уурхайн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, мэргэжлийн хяналтын байгууллагын төлөөллийг оролцуулсан ажлын хэсэг техникийн нөхцөлийн дагуу ашиглалтад хүлээж авна.

12.5. Баяжуулах цех байгуулахаар шалгарсан аж ахуйн нэгж нь тухайн газрын байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээг Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн дагуу хийлгэсэн байна.

Арван гурав. Хяналт тавих, хариуцлага хүлээлгэх

13.1. Энэхүү журмын хэрэгжилтэд мэргэжлийн хяналтыг хэрэгжүүлэх төв болон орон нутгийн байгууллага, нутгийн захиргаа, өөрөө удирдах байгууллага болон цагдаагийн байгууллага, орон нутгийн байгаль орчны болон бичил уурхайн асуудал хариуцсан ажилтан хяналт тавина.

13.2. Энэхүү журмыг зөрчсөн иргэн, хуулийн этгээд, албан тушаалтанд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол Ашигт малтмалын тухай хуулийн 66.1.9-д заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2017 оны 1 дүгээр сарын 18-ны өдөр

Улаанбаатар хот

Дугаар 20

"АЛТ-2" ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР БАТЛАХ ТУХАЙ

Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр болон Эдийн засгийг сэргээх хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор Ашигт малтмалын тухай хуулийн 9.1.2, Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 10.3, 10.6-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. ""Алт-2" үндэсний хөтөлбөр"-ийг хавсралт ёсоор баталсугай.

2. ""Алт-2" үндэсний хөтөлбөр"-ийг улсын хэмжээнд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг батлан хэрэгжүүлж, биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ц.Дашдорж, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Д.Оюунхорол, Сангийн сайд Б.Чойжилсүрэн нарт даалгаж, Монголбанкны ерөнхийлөгч Н.Баяртсайханд зөвлөсүгэй.

3. ""Алт-2" үндэсний хөтөлбөр"-ийн хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээг жил бүрийн Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд, түүнд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг улсын болон орон нутгийн төсөвт тусгаж, гадаад улс, олон улсын байгууллагын зээл, тусламжид хамруулан төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд шийдвэрлэх замаар санхүүжүүлэх арга хэмжээ авч ажиллахыг Сангийн сайд Б.Чойжилсүрэн, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ц.Дашдорж нарт үүрэг болгож, Монголбанкны ерөнхийлөгч Н.Баяртсайханд зөвлөсүгэй.

Монгол Улсын Ерөнхий сайд

Ж.ЭРДЭНЭБАТ

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд

Ц.ДАШДОРЖ

Засгийн газрын 2017 оны 20 дугаар
тогтоолын хавсралт

“АЛТ-2” ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Хөтөлбөр боловсруулах үндэслэл, шаардлага

Засгийн газрын 1991 оны 304 дүгээр тогтоолоор анх баталсан “Алт хөтөлбөр” болон “Алт-2000 хөтөлбөр”-ийг 1992-2000 онуудад хэрэгжүүлсний үр дүнд улсын хэмжээнд алтны олборлолт, экспорт эрчимтэй өсч, улсын төсвийн орлого болон гадаад валютын нөөц нэмэгдэж, тухайн үеийн эдийн засгийн хямралыг даван туулахад чухал хувь нэмрийг оруулсан болно.

Үндэсний статистикийн хорооны 2015 оны 10 дугаар сарын мэдээгээр алтны үйлдвэрлэл нь дотоодын нийт бүтээгдэхүүний 2.6 хувь, уул уурхайн салбарын үйлдвэрлэлийн 9.6 хувь, экспортын орлогын 9.1 хувийг эзэлж байгаа нь алтны үйлдвэрлэл Монгол Улсын эдийн засагт ихээхэн нөлөөтэй болохыг харуулж байна.

Хэдийгээр алт олборлолт манай улсын эдийн засагт нэг талаас эерэг нөлөө үзүүлсэн боловч нөгөө талаас далд эдийн засаг бий болох, байгаль орчныг бохирдуулах, нөхөн сэргээлтийг хангалтгүй хийх, хууль бусаар алт олборлох зэрэг тулгамдсан асуудал бий болсон.

Өмнө хэрэгжүүлсэн алт хөтөлбөрүүдийн эерэг үр дүн, сургамж болон уул уурхайн салбарт 2014-2015 онд бий болсон татвар, хууль эрх зүйн таатай орчинд тулгуурлан алтны үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, эдийн засгийн өсөлтийг дэмжихэд чиглэсэн зорилтыг хэрэгжүүлэхэд дээр дурдсан тулгамдсан асуудлыг шийдвэрлэх, алтны үйлдвэрлэлийн талаар Засгийн газраас баримтлах цаашдын зорилго, зорилтыг тодорхойлж, хэрэгжүүлэх шаардлага тавигдаж байна.

Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого, Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030, Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр болон Эдийн засгийг

сэргээх хөтөлбөрт алтны үйлдвэрлэлийг эрчимжүүлэх замаар улс эх орны эдийн засгийн чадавхийг дээшлүүлэх, тогтвортой өсөлтийг хангах зорилтууд тусгагдсан нь энэхүү хөтөлбөрийг боловсруулах үндэслэл болж байна.

1.2. Хөтөлбөрийн хамрах хүрээ

“Алт-2” үндэсний хөтөлбөр”-ийн хүрээнд дараах үйл ажиллагааг хамруулж хэрэгжүүлнэ:

1.2.1. алтны чиглэлээр геологийн судалгаа, эрэл, хайгуул хийх, алт олборлох, боловсруулах, борлуулах, экспортод гаргах;

1.2.2. байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, уурхайн хаалт болон эрүүл ахуй, хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, бичил уурхай эрхлэх.

Хоёр. Хөтөлбөрийн зорилго, зорилт

2.1. Хөтөлбөрийн зорилго

Монгол Улсын алтны үйлдвэрлэлийн ойрын болон дунд хугацааны тогтвортой хөгжлийг хангаж алт олборлох, боловсруулах үйл ажиллагаанд дэвшилтэт техник, технологи, менежмент нэвтрүүлэх, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн үр дүнг сайжруулах, алтны үйлдвэрлэлээс эдийн засагт оруулах өгөөжийг нэмэгдүүлэх, эдийн засгийн чадавхийг өсгөхөд энэхүү үндэсний хөтөлбөрийн гол зорилго оршино.

2.2. Хөтөлбөрийн зорилгыг хэрэгжүүлэх зорилгоор дараах зорилтыг дэвшүүлж байна:

2.2.1. татвар, хууль эрх зүйн таатай, тогтвортой орчинг бүрдүүлэх;

2.2.2. геологийн судалгаа, эрэл, хайгуулын ажлыг алтны хэтийн төлөв бүхий бүсийн хэмжээнд нэмэгдүүлэх замаар Монгол Улсын ашигт малтмалын сан хөмрөгийг тогтвортой арвижуулан баяжуулах;

2.2.3. алтны үйлдвэрлэлийг эрчимжүүлэх, техник, технологийг сайжруулж шинэчилснээр олборлох алтны хэмжээ, металл авалтын хувь, хэмжээг өсгөх, нэмүү өртөг шингэсэн эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, үйлчилгээг өргөжүүлэх;

2.2.4. алтны үйлдвэрлэлийн явцад байгаль орчныг хамгаалах болон үйлдвэрлэл явагдаж дууссаны дараа нөхөн сэргээх үйл ажиллагаанд хяналт, хариуцлагын иж бүрэн тогтолцоог бий болгох;

2.2.5. бичил уурхайгаар алт олборлох, борлуулах үйл ажиллагааг боловсронгуй болгох.

Гурав. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үе шат, үйл ажиллагаа

Хөтөлбөрийг ойрын болон дунд хугацааны 2 үе шаттайгаар 4 жилийн хугацаанд хэрэгжүүлнэ:

Нэгдүгээр үе шат буюу ойрын хугацаанд (2017-2018 он): Алтны үйлдвэрлэлтэй холбоотой харилцаанд мөрдөгдөж байгаа хууль тогтоомжийг боловсронгуй болгох, геологийн судалгаа, эрэл хайгуулын ажлыг эрчимжүүлэх, аж ахуйн нэгжүүдэд санхүүгийн дэмжлэг үзүүлснээр алтны олборлолтыг нэмэгдүүлэх, бэлтгэгдсэн ордыг эдийн засгийн эргэлтэд оруулах, хууль бусаар алт олборлох үйл ажиллагааг цэгцлэх ажлыг эхлүүлнэ.

Хоёрдугаар үе шат буюу дунд хугацаанд (2019-2020 он): Алтны эрэл хайгуул хийх болон олборлох, үйлдвэрлэхэд дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлж алтны олборлолт, үйлдвэрлэлийг тогтвортой өсгөх, байгаль орчин, нөхөн сэргээлтийн ажлыг эрчимжүүлэх, хяналт, хариуцлагын тогтолцоог боловсронгуй болгох арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

Хөтөлбөрт дэвшүүлсэн зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

3.1. “Хөтөлбөрийн хүрээнд татвар, хууль эрх зүйн таатай, тогтвортой орчинг бүрдүүлэх” зорилтын хүрээнд:

3.1.1. алтны үйлдвэрлэлийн татварын орчин, санхүүгийн тогтолцоог боловсронгуй болгох асуудлыг судалж, олон улсын чиг хандлагатай уялдуулан хөгжүүлэх хууль эрх зүйн орчинг бүрдүүлэх;

3.1.2. тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд орон нутгаас тавьдаг шаардлагыг хуулийн хүрээнд тодорхой болгох, алтны үйлдвэрлэлийн салбарын хүрээнд төрийн үйлчилгээг хөнгөн шуурхай, хүнд сурталгүй болгох;

3.1.3. алт агуулсан хүдэр, элс олборлож баяжуулах, хамгаалах, хадгалах, тээвэрлэх болон худалдахтай холбогдсон журмыг шинэчлэн боловсруулж мөрдөх;

3.1.4. алт олборлох болон баяжуулах, боловсруулах үйл ажиллагаанд тавигдах технологийн шаардлага, олборлолтын үеийн металл авалтын нормативт хязгаарыг тогтоож, холбогдох стандартыг боловсруулж мөрдүүлэх;

3.1.5. алтны зах зээл дэх эрэлт, хэрэгцээ, үнийн дунд хугацааны төсөөллийг тодорхойлох, алтны олборлолт, борлуулалтаас орох төсвийн болон экспортын орлогыг оновчтой төлөвлөх;

3.1.6. алт олборлогч аж ахуйн нэгжүүдэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх, алт олборлолтын хүчин чадлыг нэмэгдүүлж олборлосон алтыг худалдан авах боломжийг бүрдүүлэх зорилгоор зээл олгох хууль эрх зүйн таатай орчинг бүрдүүлж хэрэгжүүлэх;

3.1.7. алтны олборлолтын ажил төвлөрөн явагдаж байгаа нутаг дэвсгэрийн хэмжээнд нэгдсэн зохион байгуулалт бүхий бүсийг тогтоон алтны нөөцийг өсгөх, олборлолтыг нэмэгдүүлэх, нөхөн сэргээлтийн ажлыг иж бүрэн цогцоор нь хэрэгжүүлэх ;

3.1.8. хууль бусаар алт олборлох үйл ажиллагааг таслан зогсоохтой холбоотой эрх зүйн орчинг сайжруулах;

3.1.9. зэс болон бусад металлын баяжмал дахь үнэт металлыг боловсруулах, нэмүү өртөг шингэсэн эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх үйл ажиллагааг татварын болон хөрөнгө оруулалтын бодлогоор дэмжих;

3.1.10. “Алтны бирж” байгуулах боломжийг судалж, хууль эрх зүйн орчинг бүрдүүлэх;

3.1.11. алтыг орон нутагт худалдан авах үйл ажиллагааг Монголбанкны салбар болон арилжааны банкаар гүйцэтгүүлэх боломжийг судлан хэрэгжүүлэх;

3.1.12. бичил уурхайгаар олборлосон алтыг худалдан авах, хадгалах, тээвэрлэх болон сорьц тогтоох үйл ажиллагаатай холбогдсон дүрэм, журмыг шинээр боловсруулан мөрдүүлэх.

3.2. Геологийн судалгаа, эрэл, хайгуулын ажлыг алтны хэтийн төлөв бүхий бүсийн хэмжээнд нэмэгдүүлэх замаар Монгол Улсын ашигт малтмалын сан хөмрөгийг тогтвортой арвижуулан баяжуулах зорилтын хүрээнд:

3.2.1. алтны хэтийн төлөв бүхий бүс нутгийн хэмжээнд улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх геологийн болон алтны сэдэвчилсэн

судалгаа, ерөнхий эрлийн ажлыг жил бүрийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, тухайн жилийн улсын төсвийн төсөлд тусгуулан хэрэгжүүлэх;

3.2.2. улсын алтжилт бүхий өмнөд хил орчмын бүс, зарим тусгай хамгаалалттай газар нутагт геологийн судалгааг явуулж үнэлгээ өгөх, цаашдын чиглэлийг тодорхойлох;

3.2.3. алтны эрэл хайгуулын болон геологийн зураглалын ажилд олон улсад нэвтэрсэн дэвшилтэт техник, технологийг Монгол Улсад нутагшуулах, хайгуулын ажлын арга зүй, түүнд тавигдах шаардлагыг шинэчилж мөрдүүлэх;

3.2.4. алтны хэтийн төлөв бүхий талбайд сонгон шалгаруулалтын журмаар хайгуулын тусгай зөвшөөрөл олгох ажлыг тэргүүн ээлжинд зохион байгуулах;

3.2.5. алтны нөөцийн бүртгэл, эрэл хайгуулын ажлын мэдээллийг тогтмол шинэчлэн, нөөц хөдөлгөөнийг жил бүр хийж баталгаажуулах.

3.3. Алтны үйлдвэрлэлийг эрчимжүүлэх, техник, технологийг сайжруулж шинэчилснээр олборлох алтны хэмжээ, металл авалтын хувь, хэмжээг өсгөх, нэмүү өртөг шингэсэн эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, үйлчилгээг өргөжүүлэх зорилтын хүрээнд:

3.3.1. алт олборлох, боловсруулах үйл ажиллагаанд хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөлөл багатай, байгаль орчинд ээлтэй дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэх;

3.3.2. хариуцлагатай ил тод уул уурхайг хөгжүүлэх, олон улсын туршлага, алтны эдийн засгийн үр өгөөж, орон нутгийн хөгжилд оруулж байгаа хувь нэмэр, алтны борлуулалтаас олох орлогын зарцуулалтын талаар олон нийтэд сурталчлан ойлгуулахад чиглэсэн мэдлэг, боловсрол олгох сургалт зохион байгуулах;

3.3.3. ойролцоо болон хил залгаа орших тусгай зөвшөөрөл бүхий алтны ордуудын ашиглалтын үеийн тосгон, дэд бүтэц, зам, цахилгаан хангамж болон алт боловсруулах үйлдвэрийг цогц байдлаар төлөвлөн байгуулах боломжийг судлан хэрэгжүүлэх;

3.3.4. стратегийн ач холбогдол бүхий алтны ордуудын ашиглалтыг эхлүүлэх;

3.3.5 алтны болон алт агуулсан бусад ашигт малтмалын ордуудад судалгаа хийж, үнэлгээ өгөх замаар эдийн засгийн эргэлтэд оруулахад шаардлагатай нөхцөлийг тодорхойлсны үндсэн дээр зохих дэмжлэг үзүүлэх;

3.3.6. Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, олборлох, ашиглахыг хориглох тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн хүрээнд шороон болон үндсэн ордыг цаашид зохистой ашиглах нөхцөлийг бүрдүүлэх;

3.3.7. Үнэт металлын сорьцын хяналтын байгууллагыг бэхжүүлж техник технологийг шинэчлэх, алт олборлолтын томоохон бүс нутагт сорьцын салбар лаборатори байгуулах нөхцөлийг хангах, хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны хяналтын тогтолцоог сайжруулах;

3.3.8. алт цэвэршүүлэх үндэсний үйлдвэр байгуулах;

3.3.9. алтыг боловсруулж нэмүү өртөг шингэсэн эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх;

3.3.10. дэлхийн алтны олборлолт, худалдаа, олон улсын зах зээлийн үнэ, Монголбанкны сар бүрийн алтны худалдан авалтын тухай мэдээллийн нэгдсэн сан бий болгох;

3.3.11. алтны олборлолт, боловсруулалт, нөхөн сэргээлт, уурхайн хаалтын үйл ажиллагааг стандартын түвшинд гүйцэтгэж, Монголбанкинд алт тушаасан үндэсний компанийн үйл ажиллагаанд зохих дэмжлэг үзүүлэх;

3.3.12. алтны үйлдвэрлэлд ажиллагсдын чадавхийг дээшлүүлэх, мэргэшүүлэх сургалтыг тогтмол зохион байгуулах, олон жил үр бүтээлтэй ажиллаж байгаа алт олборлогч аж ахуйн нэгж, ажиллах хүчний судалгааг хийж урамшууллын механизмыг бий болгох.

3.4. Алтны үйлдвэрлэлийн явцад байгаль орчинг хамгаалах болон үйлдвэрлэл явагдаж дууссаны дараа нөхөн сэргээх үйл ажиллагаанд хяналт, хариуцлагын иж бүрэн тогтолцоог бий болгох зорилтын хүрээнд:

3.4.1. алтны үйлдвэрлэлийн улмаас эвдрэлд орсон талбайн бүртгэл тооллого болон нарийвчилсан байр зүйн зураглал хийж, хохирлын хэмжээг тогтоосны үндсэн дээр нөхөн сэргээлт хийх нарийвчилсан төлөвлөгөө боловсруулан буруутай хуулийн этгээдээр нөхөн сэргээлт хийлгэх замаар алт олборлогч аж ахуйн нэгжийн хариуцлагыг өндөржүүлэх, нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх;

3.4.2. алт олборлолтын үйл ажиллагаа эрхэлж байгаа аж ахуйн нэгжийг бүртгэлжүүлж, тэдгээрт тавих хяналт, хариуцлагын

тогтолцоог бий болгох, төрийн байгууллагын ажлын уялдаа холбоо, хамтын ажиллагааг сайжруулах нөхцөлийг бүрдүүлэх;

3.4.3. алтны орд ашигласны улмаас хүний эрүүл мэнд, байгаль орчин, нийгэмд үзүүлж байгаа сөрөг нөлөөллийн үнэлгээг тодорхойлох олон улсын туршлагыг судлан холбогдох аргачлалыг боловсруулж нэвтрүүлэх;

3.4.4. хууль бусаар алт олборлолтод өртсөн талбайн бүртгэл хийж, эрх бүхий төрийн байгууллагатай хамтран хууль бусаар алт олборлосон этгээдийг тогтоож, хариуцлага тооцон хохирлыг барагдуулах арга хэмжээ авах;

3.4.5. хууль бусаар алт олборлосон талбайд нөхөн сэргээлт, хаалт хийх нөхцөл бүрдүүлэх;

3.4.6. алтны үйлдвэрлэлийн улмаас тухайн уурхайн нөлөөллийн бүс нутгийн байгаль орчин, хүний эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөллийг үнэлэх, судлан хянах, тандах тогтолцоог бүрдүүлж алтны салбарт ажиллагсад, орон нутгийн хүн амын эрүүл мэндийг хамгаалах;

3.4.7. хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны хяналтын тогтолцоог сайжруулах;

3.4.8. уурхайн хаалтын хүрээнд алт олборлолтын онцлогт тохирсон зохицуулалтыг бий болгох, алт олборлосны дараа уурхайн хаалт хийгдсэн талбайд хяналт шалгалт хийх, талбайг тухайн орон нутагт хүлээлгэн өгөх журмыг тодорхой болгох.

3.5. бичил уурхайгаар алт олборлох, борлуулах үйл ажиллагааг боловсронгуй болгох зорилтын хүрээнд:

3.5.1. бичил уурхайгаар алт олборлоход ашиглаж байгаа техникийн стандартыг боловсронгуй болгох, хаягдал багатай ашиглах технологийг нэвтрүүлэх, бичил уурхайгаар олборлосон алтыг худалдан авах болон борлуулах албан ёсны сүлжээ бий болгох;

3.5.2. бичил уурхай эрхлэх талбайг улсын хэмжээнд нарийвчлан тогтоож, бүртгэж байх;

3.5.3. бичил уурхайгаар алт олборлогч иргэдийг албан ёсны болгох, нөхөрлөлийг чадавхижуулж бүртгэх замаар цаашид хуулийн этгээд болгон өөрчлөн зохион байгуулахад дэмжлэг үзүүлж, хүн амын орлогын болон бусад татвар, төлбөр, хураамж ногдуулах оновчтой тогтолцоог бий болгох;

3.5.4. алтны ордыг ашиглах явцад үүссэн хаягдал нөөцийг бүртгэлжүүлж, үнэлгээ хийх;

3.5.5 бичил уурхай эрхлэгчдэд хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, техник хангамж болон нөхөн сэргээлтийн талаар сургалт явуулах;

3.5.6. тусгай зөвшөөрөл нь хүчингүй болж орхигдсон талбайд байгаа үүсмэл ордуудыг ашиглах үйл ажиллагаанд орон нутгийн нөхөрлөлийг оролцуулахад дэмжлэг үзүүлэх.

Дөрөв. Хөтөлбөрийн үр нөлөө, шалгуур үзүүлэлт

4.1. “Алт-2” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлснээр дараах үр дүн гарна:

4.1.1. алт олборлолт, үйлдвэрлэл болон борлуулалттай холбоотой эрх зүй, татварын тогтвортой орчин бүрдэж, алтны хайгуул болон олборлолтын салбарт хөрөнгө оруулалт нэмэгдсэн байна;

4.1.2. алтны ордуудын нөөцийн үнэлгээ, нөөцийн хөдөлгөөний бүртгэл шинэчлэгдэж, түүнийг тогтмол баяжуулан хөтөлдөг болсон байна;

4.1.3. хөтөлбөр хэрэгжих хугацаанд гүйцэтгэсэн эрэл хайгуулын ажлын үр дүнд Монгол Улсын алтны нөөц 100-150.0 тонноор нэмэгдсэн байна;

4.1.4. алтны олборлолтын хэмжээг жилд 2-3 тонноор нэмэгдүүлж, улмаар 2020 онд 25 тоннд хүргэсэн байна;

4.1.5. алтны хяналт хариуцлагын тогтолцоо төлөвшин бүрдсэн байна;

4.1.6. алтны олборлолт, боловсруулалт, хүний эрүүл мэнд, байгаль орчин, уурхайн хаалтын менежментийн дэвшилтэт техник, технологи, аргачлал, олон улсын тэргүүн туршлагыг нэвтрүүлж, алтны хаягдлыг багасган алтны уурхайн талбайг стандартын дагуу нөхөн сэргээж, уурхайн хаалтыг хийдэг болсон байна;

4.1.7. алт цэвэршүүлэх үйлдвэр байгуулагдсанаар бүтээгдэхүүнийг олон улсын зах зээлд шууд борлуулах боломж бүрдэхийн зэрэгцээ үнэт металлын эцсийн бүтээгдэхүүнийг дотооддоо үйлдвэрлэдэг жижиг, дунд үйлдвэрлэл хөгжиж, шинээр ажлын байр бий болсон байна;

4.1.8. Монголбанкинд тушаах алтны хэмжээ тогтвортой өсч, гадаад валютын нөөц нэмэгдсэнээр үндэсний валютын ханш тогтворжиж, Монгол Улсын зээлжих зэрэглэл, төлбөрийн чадвар сайжирсан байна;

4.1.9. бичил уурхайгаар алт олборлогч иргэдийг албан ёсны болгох, татвар ногдуулах оновчтой тогтолцоонд шилжсэнээр улсын болон орон нутгийн төсөвт оруулах орлого нэмэгдсэн байна.

4.2. Хөтөлбөрийн үр дүнг дараах шалгуур үзүүлэлтээр үнэлж дүгнэнэ:

4.2.1. хууль тогтоомж, тогтолцоо, зохион байгуулалтын өөрчлөлт, шинэчлэлт;

4.2.2. алтны нөөцийн өсөлт;

4.2.3. металл авалтын нэмэгдэл, алт цэвэршүүлэх нөхцөлийн бүрдэлт;

4.2.4. алтны ордуудын иж бүрэн ашиглалт;

4.2.5. алтны уурхайн хаалттай холбоотой эрх зүйн зохицуулалт.

Тав. Хөтөлбөрийн санхүүжилтийн эх үүсвэр, шаардагдах хөрөнгийн хэмжээ

Хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан төсөл, арга хэмжээ, үйл ажиллагааг дараах хөрөнгийн эх үүсвэрээс санхүүжүүлнэ:

5.1. аж ахуйн нэгж, бичил уурхайчдын нөхөрлөлийн өөрийн хөрөнгө оруулалт;

5.2. улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт;

5.3. гадаад болон дотоодын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжүүдийн хөрөнгө оруулалт;

5.4. олон улсын байгууллага, хандивлагч орны зээл, тусламж;

5.5. зээл болон бондын эх үүсвэр;

5.6. Монголбанк болон Хөгжлийн банкны эх үүсвэр.

Зургаа. Хөтөлбөрийн хяналт-шинжилгээ, үнэлгээ

6.1. “Алт-2” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх байнгын ажиллагаатай орон тооны бус Зөвлөлийг уул уурхайн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнээр ахлуулан байгуулна. Зөвлөл нь “Алт-2” үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг улсын хэмжээнд удирдан зохион байгуулах, уялдуулан зохицуулах, тайлагнах чиг үүрэгтэй байна.

6.2. “Алт-2” үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтэд уул уурхайн болон байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ.

-----oOo-----

АШИГТ МАЛТМАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2011 оны 4 дүгээр
сарын 21-ний өдөр

Дугаар 153

Улаанбаатар хот

Дүрэм, заавар, маягт, гэрээний загвар батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын 2010 оны 308 дугаар тогтоолоор батлагдсан “Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.3 дахь заалтуудыг үндэслэн ТУШААХ НЬ:

1. “Ашигт малтмал олборлох тухай гэрээ байгуулах өргөдөл”-ийн маягыг 1 дүгээр хавсралтаар, “Ашигт малтмал олборлох гэрээ”-ний загварыг 2 дугаар хавсралтаар, “Ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий талбайгаас бичил уурхайгаар ашигт малтмал олборлох тухай гурвалсан гэрээ”-ний загварыг 3 дугаар хавсралтаар, “Бичил уурхайн нөхөн сэргээлтийн заавар”-ыг 4 дүгээр хавсралтаар, “Бичил уурхайн хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны дүрэм”-ийг 5 дугаар хавсралтаар, “Бичил уурхай эрхлэгчдийн үйл ажиллагааны талаархи мэдээллийн маягт”-ыг 6 дугаар хавсралтаар, “Бичил уурхайн байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх болон хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны хүрээнд авах арга хэмжээний төлөвлөгөө, тайлангийн маягт”-ыг 7 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Ашигт малтмал, газрын тосны хэрэг эрхлэх газрын даргын 2008 оны 149, 253 дугаар тушаалыг хүчингүй болгосугай.

3. Энэхүү тушаалаар батлагдсан гэрээ, дүрэм, заавар, маягтын загварыг бичил уурхайгаар ашигт малтмал олборлох үйл ажиллагаанд хэрхэн ашиглах, дагаж мөрдөх талаар бичил уурхай эрхлэгчид болон аймаг, сум, дүүргийн Засаг дарга, Засаг даргын дэргэдэх холбогдох байгууллага, Иргэдийн Төлөөлөгчдийн хуралд мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх, сурталчлах ажлыг зохион байгуулахыг Уул уурхай, судалгааны хэлтэс /Ц.Даваацэрэн/-т даалгасугай.

4. “Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам”-ын хэрэгжилт болон энэ тушаалаар батлагдсан дүрэм, заавар, маягт, гэрээний загварыг хэрэглэж байгаа практикийг судалж боловсронгуй болгох санал боловсруулж 2011 оны 12 дугаар сарын 1-ний дотор танилцуулахыг Уул уурхай, судалгааны хэлтэс /Ц.Даваацэрэн/-т үүрэг болгосугай.

5. Энэхүү тушаалын биелэлтэнд хяналт тавьж тушаалыг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэхийг Захиргаа, удирдлагын хэлтэс /Б.Түвшинжаргал/-т даалгасугай.

ДАРГА

Д.БАТХУЯГ

АМГ-ын даргын 2011 оны 153
тушаалын нэгдүгээр хавсралт

Маягт -1

(Энэхүү өргөдлийг гаргацтай, засваргүй бичиж бөглөнө үү

..... аймгийн сум, дүүргийн
Засаг дарга /
..... /
Танаа

**Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох тухай гэрээ
байгуулах өргөдөл гаргах нь:**

..... оны сарын өдөр

“ ” бүртгэгдээгүй нөхөрлөлийг
төлөөлж тус нөхөрлөлийн ахлагч овогтой
..... -с аймаг (хот)-ийн
..... сум (дүүрэг)-ийн нутаг дэвсгэрт байршилтай
..... нэртэй газарт
..... олборлох

(ашигт малтмалын төрөл)

гэрээ байгуулахыг хүсч өргөдөл гаргаж байна. Өргөдлийг хянан үзэж
шийдвэрлэж өгнө үү.

Өргөдөлд дараах бичиг баримтыг хавсаргав. Энэ зайг өргөдөл
хүлээн авагч бөглөнө

1. Нөхөрлөлийн гишүүдийн иргэний
үнэмлэхийн хуулбар; ☐
2. Нөхөрлөлийн гишүүдийн хооронд бичгээр
байгуулсан хамтран ажиллах гэрээ; ☐
3. Нөхөрлөлийн олборлолт явуулах талбайн
байршлын зураг; ☐
4. Нөхөрлөлийн гишүүдийн албан татвар төлөгчийн
гэрчилгээ, дэвтрийн хуулбар; ☐

5. Нөхөрлөлийн гишүүдийн эрүүл мэнд, нийгмийн даатгалын дэвтрийн хуулбар; ☐
6. Нөхөрлөлийн гишүүдийн дэлгэрэнгүй мэдээлэл; ☐
7. Нөхөрлөлийн гишүүн тухайн орон нутагт оршин суугч болохыг тодорхойлсон баримт ☐

Өргөдөл гаргасан: /
/гарын үсэг/ /нэр/

Өргөдлийг хүлээн авсан тухай тодорхойлолт:

Өргөдлийг 20 . . . оны . . . сарын өдрийн . . . цаг . . . минутанд хүлээн авч өргөдлийн бүртгэлийн дугаарт бүртгэв.

Өргөдлийг хүлээн авч, бүртгэсэн ажилтан /
/нэр /

АМГ-ын даргын 2011 оны 153
тушаалын хоёрдугаар хавсралт

**Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох тухай гэрээ
(Гэрээний загвар)**

20. . . оны . . . сарын . . . өдөр Дугаар
/байрлал/

Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журмын 8.1, 8.2 дахь заалтын дагуу нэг талаас аймаг (хот)-ийн сум (дүүрэг)-ын Засаг дарга овогтой (цаашид “Засаг дарга” гэх), нөгөө талаас бичил уурхайн “ ” нэртэй бүртгэгдээгүй нөхөрлөл (цаашид “Нөхөрлөл” гэх)-ийг төлөөлж нөхөрлөлийн ахлагч овогтой бид нар харилцан тохиролцож энэхүү гэрээ (цаашид “Гэрээ” гэх)-г байгуулав.

Нэг. Ерөнхий зүйл

1.1. Нөхөрлөл нь сум(дүүрэг)-ийн нэртэй газарт орших гектар талбайд нэг жилийн хугацаагаар олборлох үйл ажиллагаа эрхлэнэ.
/ашигт малтмалын төрөл/

1.2. Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох талаар сум (дүүрэг)-ын Засаг дарга, нөхөрлөлийн хооронд үүсэх харилцааг энэхүү гэрээгээр зохицуулна.

Хоёр. Сум, дүүргийн Засаг даргын эрх, үүрэг

2.1. Сум, дүүргийн Засаг дарга дараах үүрэг хүлээнэ. Үүнд:
2.1.1. “Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам”-ын 3-т заасан үүрэг хүлээнэ
2.1.2. Нөхөрлөлд ногдох талбайн хэмжээг тогтоож, талбайн байршлын зургийг гэрээнд хавсаргах;

2.2.3. Нөхөрлөлийн гишүүдийн амьдрах суурьшлын бүс болон хог хаягдлын цэгийн байршлыг тогтоож өгөх;

2.2.4. Нөхөрлөлийн олборлосон ашигт малтмалыг баяжуулах, ангилах, ялгах цэг, талбай буюу зориулалтын баяжуулах цехийн байршлыг тогтоож өгөх;

2.2.5. Олборлолт явуулсан талбайг буцаан хүлээлгэж өгөхийн өмнө хийх нөхөн сэргээлтийн зааврыг нөхөрлөлд танилцуулж ойлголцсон байх;

2.2.6. Нөхөрлөлд ногдох талбайн хэмжээтэй уялдуулан олборлолт явуулсан талбайд хийх техникийн болон биологийн нөхөн сэргээлтийн ажлын зардлыг тооцож, нөхөн сэргээлтийн дундын санд төвлөрүүлэх мөнгөний хэмжээ, хугацааг нөхөрлөлтэй харилцан тохиролцож зохих хөрөнгийг төвлөрүүлэх;

2.2.7. “Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны дүрэм”-ийг дагаж мөрдөж байгаа эсэх, ажлын байрны зааварчлага өгөх үүргээ нөхөрлөлийн ахлагч биелүүлж байгаа эсэхэд хяналт тавих;

2.2.8. Гишүүдийг хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны арга барилд сургах ажлыг мэргэжлийн байгууллагын тусламжтайгаар зохион байгуулах,

2.2.9. Нөхөрлөлийн олборлосон ашигт малтмалыг хууль тогтоомжийн дагуу худалдах үйл ажиллагаанд хяналт тавих, олборлолтын мэдээ хөтлөх;

2.2.10. Нөхөрлөлийн гишүүдэд эрүүл мэнд, нийгмийн даатгалд хамрагдахын ач холбогдолыг тайлбарлан таниулах ажлыг мэргэжлийн байгууллагын тусламжтайгаар зохион байгуулах, эрүүл мэнд, нийгмийн даатгалд хамруулах.

2.2.11. Нөхөрлөлөөс талбайг буцааж хүлээлгэж өгөхийн өмнө хийсэн нөхөн сэргээлтийн ажлыг газар дээр нь байгаль орчны хяналтын байцаагчийн дүгнэлт гаргуулан, комисс томилж хүлээн авах;

2.2.12. Нөхөрлөлд ашигт малтмал олборлох талбай дахин олгох асуудлыг шийдвэрлэх;

2.2.13. Нөхөрлөлд гэрээгээр олгосон талбай дээр нөхөрлөлийн гишүүн бус этгээд ажиллаж буй эсэхэд хяналт тавих;

2.2.14. Нөхөрлөлийн гишүүдэд бичил уурхай эрхлэгчийн хувьд хууль тогтоомжийн дагуу татвар төлөх үүргийг нь тайлбарлан таниулж, татварын үүрэг биелүүлэхтэй нь холбогдсон сургалт сурталчилгааны ажлыг зохион байгуулах;

2.3. Засаг дарга дараах эрхтэй. Үүнд:

2.3.1. “бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам”-ын 3-т заасан эрх эдэлнэ

2.3.2. Нөхөрлөлд энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг шаардах;

2.3.3. Нөхөрлөлийн ахлагчид үүрэг даалгавар өгөх, гүйцэтгэлийг шалгах;

2.3.4. Гэрээний үүргээ биелүүлээгүй, ашигласан талбайн нөхөн сэргээлт хийгээгүй нөхөрлөлийн ашигт малтмал олборлох үйл ажиллагааг зогсоож, гэрээг цуцлах;

2.3.5. Хүн, мал, байгаль орчинд харш үйл ажиллагааг зогсоох;

Гурав. Нөхөрлөлийн эрх, үүрэг

3.1. Нөхөрлөл дараах үүрэгтэй. Үүнд:

3.1.1. Нөхөрлөлийн гишүүдийг тогтоосон бүсэд суурьшуулах;

3.1.2. Нөхөрлөл нь гэрээнд заасан талбайн хил, хязгаарын дотор үйл ажиллагаа явуулах;

3.1.3. Байгаль орчныг хамгаалах, гол ус, булаг шанд, уст цэгүүдийг бохирдуулахгүйгээр зүй зохистой хэрэглэх;

3.1.4. Орчны тохижилт хийх, хог, хаягдлын цэгийг байгуулах;

3.1.5. Бичил уурхайн хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны дүрмийг дагаж мөрдөх, осол аваараас урьдчилан сэргийлэх арга техникт суралцах;

3.1.6. Ашигт малтмалыг баяжуулах, ялгаж ангилах үйл ажиллагааг тогтоосон зориулалтын цэг талбайд гүйцэтгэх;

3.1.7. Байгаль орчныг нөхөн сэргээх талаар хүлээсэн үүргээ биелүүлэх баталгаа болгож сум, дүүргийн Засаг даргын тогтоосон байгаль орчны нөхөн сэргээлтийн зардалд шаардагдах / /төгрөгийг нөхөн сэргээлтийн дундын санд төвлөрүүлэх;

3.1.8. Нөхөн сэргээлтийн дундын санд төвлөрүүлсэн хөрөнгийг олборлолт явуулсан талбайн нөхөн сэргээлтэнд зарцуулах;

3.1.9. Талбайг хүлээлгэн өгөхийн өмнө нөхөн сэргээлт хийж сумын байгаль орчны хяналтын улсын байцаагчаар дүгнэлт гаргуулан, сум, дүүргийн Засаг даргын томилсон комисст хүлээлгэн өгөх;

3.1.10. Олборлосон ашигт малтмалыг хууль тогтоомжийн дагуу худалдан авах эрх бүхий хуулийн этгээдэд худалдана;

3.1.11. Бичил уурхайн хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаа болон байгаль орчны нөхөн сэргээлт хийхэд чиглэгдсэн сургалт, сурталчилгаанд гишүүдийг идэвхитэй оролцуулах;

3.1.12. Холбогдох хууль тогтоомжийн дагуу бичил уурхай эрхлэгч иргэний орлогын албан татвар төлөх;

3.1.13. Хууль ёс, нийгмийн хэв журмыг зөрчсөн аливаа үйлдэлтэй хамт олноороо тэмцдэг байх;

3.1.14. Үйл ажиллагаандаа химийн хорт болон аюултай бодис ашиглахгүй байх, тусгай зөвшөөрөлтэй этгээдээр гүйцэтгүүлэхээс бусад тохиолдолд тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэлийг ашиглахгүй байх;

3.1.15. Нөхөрлөлд гэрээгээр олгосон талбайд зөвхөн нөхөрлөлийн гишүүнийг ажиллуулах;

3.1.16. Ашигт малтмал олборлолтын үйл ажиллагаанд 500 см³-ээс дээш багтаамжтай дотоод шаталтат хөдөлгүүр бүхий механизмыг ашиглахгүй байх.

3.2. Нөхөрлөл дараах эрхтэй. Үүнд:

3.2.1. Нөхөрлөлд олгосон талбайд ашигт малтмал олборлох үйл ажиллагаагаа явуулах;

3.2.2. Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлт хийх болон нийгмийн асуудлыг шийдвэрлэх, бичил уурхайн бүтэц, зохион байгуулалт, технологи сайжруулахтай холбогдсон санал, санаачлага гаргах;

3.2.3. Нөхөн сэргээлт хийсэн талбайг хүлээлгэн өгсөний дахин ашигт малтмал олборлох гэрээ байгуулах өргөдөл гаргах;

Дөрөв. Харилцан хүлээх үүрэг

4.1. Гэрээнд оролцогч талууд харилцан хүндэтгэх зарчим дээр тулгуурлан хамтарч ажиллана.

4.2. Гэрээний дагуу олборлолт явуулж байгаа нөхөрлөлийн буруутай үйл ажиллагаанаас шалтгаалан байгаль орчин, хүн малд ноцтой хохирол учирвал нөхөрлөл уг хохирлыг барагдуулах үүрэг хүлээх ба Засаг дарга тухайн нөхөрлөлөөс уг хохирлыг барагдуулахыг шаардах үүрэгтэй.

Тав. Маргаан шийдвэрлэх

5.1. Гэрээтэй холбоотой маргааныг талууд харилцан тохиролцох замаар шийдвэрлэнэ.

5.2. Талууд тохиролцоонд хүрээгүй тохиолдолд Монгол Улсын хууль, тогтоомжийн дагуу маргааныг шийдвэрлэнэ.

Зургаа. Гэрээний үйлчлэх хугацаа

6.1. Энэхүү гэрээ нь 20. . . оны . . . сарын . . . өдрөөс . . . 20 . . . оны . . . сарын . . . өдөр хүртэл хугацаанд үйлчилнэ. Талууд гарын үсэг зурж баталгаажуулсан өдрөөс эхлэн гэрээ хүчин төгөлдөр болно.

6.2. Бичил уурхайн нөхөрлөл гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлсэн тохиолдолд цаашид нэг жилээр гэрээг сунгаж ажиллана.

6.2. Бичил уурхайгаар ашигт малтмал олборлосон талбайд нөхөн сэргээлт хийж орон нутагт хүлээлгэж өгснөөр энэхүү гэрээний үүрэг дуусгавар болно.

6.3. Гэрээний хавсралтууд нь түүний салшгүй хэсэг байна.

6.4. Гэрээг 2 хувь үйлдэж талууд тус бүр нэг хувийг хадгална.

Гэрээ байгуулсан:

..... сум (дүүрэг)-ын
Засаг дарга

“.....” нөхөрлөлийн
ахлагч.

//

//

Хаяг:

Хаяг:

Утасны дугаар:

Утасны дугаар:

Ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий талбайгаас бичил
уурхайгаар ашигт малтмал олборлох тухай гурвалсан гэрээ
(Гэрээний загвар)

Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журмын 5.3, 5.5 дахь заалтын дагуу нэг талаас аймаг (хот)-ийн сум (дүүрэг)-ын Засаг дарга (цаашид “Засаг дарга” гэх) овогтой), нөгөө талаас тус сум (дүүрэг)-ын хэмээх газарт ашигт малтмал ашиглах дугаартай тусгай зөвшөөрөл эзэмшигч (цаашид “Тусгай зөвшөөрөл эзэмшигч” гэх) компанийн захирал овогтой, гуравдагч талаас бичил уурхайн “” бүртгэгдээгүй нөхөрлөл (цаашид “Нөхөрлөл” гэх)-ийн ахлагч овогтой бид нар харилцан тохиролцож энэхүү гурвалсан гэрээ (“Гэрээ” гэх)-г байгуулав.

1.1. Өөрийн эзэмшиж буй тусгай зөвшөөрлөөр олгогдсон талбайгаас нөхөрлөлд олборлох зориулалтаар /ашигт малтмалын нэр/ талбай ашиглуулахтай холбогдон Засаг дарга, Компани, Нөхөрлөлийн хооронд үүсэх харилцааг энэ гэрээгээр зохицуулна.

1.2. Энэхүү гэрээг 20. . . оны. . . сарын . . . өдрөөс эхлэн нэг жилийн хугацаагаар байгуулав.

2.1. Тусгай зөвшөөрөл эзэмшигч дараах үүргийг хүлээнэ. Үүнд:
2.1.1. Тусгай зөвшөөрлөөр олгогдсон талбайн дор дурьдсан солбицол бүхий цэгүүдийг холбосон шугамаар хүрээлэгдсэн

. . . гектар талбайг Нөхөрлөлд ашиглуулна.

Цэгийн дугаар	Уртраг	Өргөрөг
1		
2		
3		
4		
5		

2.1.2. Нөхөрлөлийг гэрээнд заасан солбицолын хүрээнд үйл ажиллагаа явуулж байгаа эсэхэд хяналт тавих;

2.1.3. Нөхөрлөлийг гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж байгаа эсэхэд хяналт тавих;

2.1.4. Нөхөрлөл ашигт малтмал олборлох үйл ажиллагаандаа аюулгүй ажиллагааны дүрмийг мөрдөж ажиллаж байгаа эсэхэд хяналт тавьж ажиллах, зөрчил илэрсэн толхиолдолд түүнийг арилгуулах арга хэмжээг авч хэрэгжүүлэх;

2.1.5. Ашигт малтмал олборлох явцад гэнэтийн осол, аваар гарсан тохиолдолд түүнийг арилгах, аврах ажиллагаанд дэмжлэг, туслалцаа үзүүлэх;

2.1.6. Ашигт малтмал олборлосон талбайн нөхөн сэргээлтийн ажлыг хийж гүйцэтгэхэд нөхөрлөлд дэмжлэг үзүүлж хамтран ажиллах;

2.1.7. Нөхөрлөлийн олборлосон ашигт малтмалыг баяжуулах, ангилах, ялгах цэг, талбайн байршлыг тогтоож өгөх;

2.1.8. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь нөхөрлөлийн үйл ажиллагааны тухай мэдээллийг маягтын дагуу болон хавсралт зурганд тусган уул уурхайн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад уулын ажлын төлөвлөгөөг гэрээ байгуулсаны дараа 1 сарын дотор тайланг хуулинд заасан хугацааны дотор хүргүүлнэ.

2.2. Тусгай зөвшөөрөл эзэмшигч дараах эрхтэй. Үүнд:

2.2.1. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн уурхайн хэвийн үйл ажиллагаанд саад учруулахгүй байхыг нөхөрлөлөөс шаардах;

2.2.2. Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг нөхөрлөл болон засаг даргаас шаардах;

2.2.3. Нөхөрлөл нь гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй, Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн уурхайн хэвийн үйл ажиллагаанд саад учруулсан тохиолдолд гэрээг хугацаанаас нь өмнө цуцлах тухай санал гаргах;

2.2.4. Нөхөрлөлийн гишүүдийн татвар даатгалтай холбоотой асуудлыг хариуцахгүй;

2.2.5. Гэрээт талбайгаас олборлосон ашигт малтмалыг (энэ заалт алт олборлох тохиолдолд хамаарна) хууль тогтоомжийн дагуу худалдах, худалдан авах эрх бүхий этгээдэд худалдахдаа тухайн Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нэр дээр бүртгүүлэхийг нөхөрлөлийн гишүүдээс шаардах;

2.2.6. Нөхөрлөл гэрээт талбайд үйл ажиллагаа явуулах тухай мэдээлэлээ төлөвлөгөө батлуулахдаа хавсралтаар гаргаж байх

Гурав. Засаг даргын хүлээх эрх, үүрэг

3.1. Засаг дарга дараах үүргийг хүлээнэ. Үүнд:

3.1.1. Нөхөрлөл гэрээт талбайд үйл ажиллагаа явуулж байгаа эсэхэд хяналт тавих;

3.1.2. Нөхөрлөлийн гишүүдэд “бичил уурхайн хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны дүрэм”-ийг тайлбарлан таниулах, осол аваараас урьдчилан сэргийлэх, осол аваар гарсан тохиолдолд анхан шатны тусламж үзүүлэх, осол аваар устгах талаар мэргэжлийн байгууллагаар сургалт хийлгэх ажлыг зохион байгуулах;

3.1.3. Нөхөрлөлийн гишүүдийн амьдрах суурьшлын бүс болон хог хаягдлын цэгийн байршлыг тогтоож өгөх;

3.1.5. Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх ажлын гүйцэтгэлд хяналт тавих;

3.1.6. Хуулиар олгогдсон эрх, үүргийнхээ дагуу тусгай зөвшөөрөл эзэмшигч болон нөхөрлөлийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх;

3.1.7. Нөхөрлөлийн олборлосон ашигт малтмалыг хууль тогтоомжийн дагуу эрх бүхий этгээдэд борлуулж байгаа эсэхэд хяналт тавих;

3.1.8 Нөхөрлөлийн гишүүдэд бичил уурхай эрхлэгчийн хувьд хууль тогтоомжийн дагуу татвар төлөх үүргийг нь тайлбарлан таниулж, татварын үүрэг биелүүлэхтэй нь холбогдсон сургалтг сурталчилгааны ажлыг зохион байгуулах;

3.2. Засаг дарга дараах эрхтэй. Үүнд:

3.2.1. Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг нөхөрлөл болон тусгай зөвшөөрөл эзэмшигчээс шаардах;

3.2.2 талууд гэрээний үүргээ биелүүлээгүй, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны дүрмийг дагаж мөрдөөгүй тохиолдолд нөхөрлөлийн ашигт малтмал олборлох үйл ажиллагааг зогсоож, гэрээг хугацаанаас нь өмнө цуцлах тухай санал гаргах;

3.2.3. Хуулиар олгогдсон бусад эрх, үүргээ хэрэгжүүлэх;

Дөрөв. Нөхөрлөлийн эрх, үүрэг

4.1. Нөхөрлөл нь дараах үүргийг хүлээнэ.

4.1.1. Гэрээт талбайд ашигт малтмал олборлох үйл ажиллагаа явуулах;

4.1.2. Нөхөрлөлийн гишүүд Засаг даргаас тогтоосон суурьшлын бүсэд амьдрах, тогтоосон газарт хог хаягдлын цэг байгуулах;

4.1.3. Олборлосон ашигт малтмалыг баяжуулах, ангилах, ялгах ажлыг тусгай зөвшөөрөл эзэмшигчийн тогтоож өгсөн цэгт болон зориулалтын баяжуулах цехэд гүйцэтгэх;

4.1.4. Гэрээт талбайн ашигт малтмалын нөөцийг бүрэн гүйцэд ашиглах;

4.1.5. Олборлосон ашигт малтмалыг хууль тогтоомжийн дагуу ашигт малтмалыг худалдах, худалдан авах эрх бүхий этгээдэд борлуулахдаа тухайн тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нэр дээр бүртгүүлэх;

4.1.6. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хэвийн үйл ажиллагаанд саад учруулахгүй байх;

4.1.7. Байгаль орчныг хамгаалах, голын ус, булаг шанд, уст цэгүүдийг бохирдуулахгүй байх, нөхөн сэргээлт хийх;

4.1.9. Бичил уурхайн хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны дүрмийг дагаж мөрдөх, осол аваараас урьдчилан сэргийлэх,

4.1.10. Хууль ёсыг дээдэлж, нийгмийн хэв журмыг сахин биелүүлэх;

4.1.11. Бичил уурхайн хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаа болон байгаль орчны нөхөн сэргээлт хийхэд чиглэгдсэн сургалт, сурталчилгаанд идэвхитэй оролцох;

4.1.13. Ашиглах үйл ажиллагаанд химийн хорт болон аюултай бодис ашиглахгүй байх, тусгай зөвшөөрөлтэй этгээдээр гүйцэтгүүлэхээс бусад тохиолдолд тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэлийг ашиглахгүй байх;

4.1.14. Нөхөрлөлд гэрээгээр олгосон талбайд зөвхөн нөхөрлөлийн гишүүнийг ажиллуулах;

4.1.15. Холбогдох хууль тогтоомжийн дагуу бичил уурхай эрхлэгч иргэний орлогын албан татвар төлөх;

4.2. Нөхөрлөл дараах эрхтэй. Үүнд:

4.2.1. Гэрээт талбайд ашигт малтмал ашиглах үйл ажиллагаа явуулах;

4.2.2. Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийг хийх болон нийгмийн асуудлыг шийдвэрлэх, зохион байгуулалт, технологи сайжруулахтай холбогдсон санал, санаачлага гаргах;

4.2.3. Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг тусгай зөвшөөрөл эзэмшигч болон Засаг даргаас шаардах;

Тав. Харилцан хүлээх үүрэг

5.1. Гэрээний 2.2.3-д заасны дагуу гэрээг цуцлах нөхцөл байдал бий болсон тохиолдолд гэрээг цуцлах тухай саналаа талуудад бичгээр хүргүүлэх;

5.2. Талууд харилцан хүндэтгэх зарчимаар ажиллана.

5.2. Гэрээний дагуу олборлолт явуулах явцад тусгай зөвшөөрөл эзэмшигч эсхүл нөхөрлөлийн буруутай үйл ажиллагаанаас шалтгаалан байгаль орчин, хүн малд ноцтой хохирол учирвал буруутай тал нь уг хохирлыг барагдуулах үүрэг хүлээнэ.

5.3. Энэхүү гэрээтэй холбогдон гарсан маргаантай асуудлыг талууд харилцан зөвшилцөж шийдвэрлэхийг эрмэлзэнэ. Хэрэв зөвшилцөлд хүрч чадаагүй тохиолдолд асуудлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу хууль, хяналтын байгууллагад тавьж шийдвэрлүүлнэ.

Зургаа. Гэрээ дуусгавар болох

6.1. Энэхүү гэрээ нь дараах тохиолдолд дуусгавар болно. Үүнд:

6.1.1. Гэрээний хугацаа дууссан бөгөөд гэрээг сунгаагүй;

6.1.2. Гэрээний хүчинтэй хугацаанд тусгай зөвшөөрөл хүчингүй болох эсхүл хугацаа нь дуусгавар болох;

6.1.3. Гэрээг хугацаанаас нь өмнө цуцлах талаар аль нэг тал бусад талууддаа бичгээр мэдэгдсэн боловч бусад талууд нь ажлын 14 хоногт багтаан асуудлыг шийдвэрлээгүй эсхүл хариу өгөөгүй тохиолдолд;

Долоо. Бусад зүйл

7.1. Энэхүү гэрээ нь 20. . . оны . . . сарын . . . өдрөөс . . . 20 . . . оны . . . сарын . . . өдөр хүртэл хугацаанд үйлчилнэ. Талууд гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулсан өдрөөс эхлэн гэрээ хүчин төгөлдөр болно.

7.2. Талууд гэрээний үүргээ биелүүлснээр энэхүү гэрээний үүрэг дуусгавар болно.

7.3. Гэрээний хавсралтууд нь түүний салшгүй хэсэг байна.

7.4. Гэрээг 3 хувь үйлдэж талууд тус бүр нэг хувийг хадгална.

Найм. Маргаан шийдвэрлэх

8.1. Гэрээтэй холбоотой маргааныг талууд харилцан тохиролцох замаар шийдвэрлэнэ.

8.2. Талууд тохиролцоонд хүрээгүй тохиолдолд Монгол Улсын хууль, тогтоомжийн дагуу маргааныг шийдвэрлэнэ.

Гэрээ байгуулсан:

..... сум (дүүрэг)-ын

Засаг дарга

/

..... нөхөрлөлийн

Ахлагч

/...../

Хаяг:

Утасны дугаар:

..... компанийн

Захирал

/...../

Хаяг:

Утасны дугаар:

АМГ-ын даргын 2011 оны 153
тушаалын дөрөвдүгээр хавсралт

**Бичил уурхайн үйл ажиллагааны улмаас эвдрэлд
орсон газарт техникийн болон биологийн
нөхөн сэргээлт хийх заавар**

Ерөнхий шаардлага

1. Олборлолт хийх газрын ерөнхий байдлыг үнэлэн, дүрслэл зураг (хар зураг) гаргаж газар хүссэн өргөдөлд хавсаргасан байх. Уг зураглалд тухайн орчны дүрслэл, ямар зориулалтаар хэрэглэж байсан, гол горхи, булаг шанд, худаг байсан эсэх, машин болон зөрөг зам байсан эсэх гэх мэт мэдээллийг, багтаасан байхаас гадна ургамалжилтын талаарх мэдээллийг оруулна.
2. Байгаль орчныг нөхөн сэргээх төлөвлөгөөг орон нутгийн байгаль орчны байцаагчтай зөвлөсний дагуу боловсруулж батлуулах ба уг төлөвлөгөөнд нөхөн сэргээлттэй холбоотой бүх үйл ажиллагааг төлөвлөж үүнд шаардагдах хөрөнгийн хэмжээг тооцож гаргасан байна.
3. Нөхөн сэргээлтийн зориулалтаар ашиглах дундын сан байгуулах.

Бичил уурхайн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрыг 2 хэлбэрээр нөхөн сэргээлт хийнэ. Үүнд:

А. Ашиглалтын болон технологийн хаягдлаар бий болсон үүсмэл орд

“Үүсмэл орд” гэж олборлолт, боловсруулалтын үйл ажиллагааны улмаас бий болсон ашигт малтмалын тодорхой агуулга бүхий дахин боловсруулахад эдийн засгийн үр ашиг гаргаж болох, эрх бүхий байгууллагаас зөвшөөрсөн хөрс, шороог хэлнэ.

1. Техникийн нөхөн сэргээлт:

Техникийн нөхөн сэргээлт нь эвдрэлд орсон газарт тэгшлэлт хийн хэлбэржүүлж ургамалжуулахад бэлтгэн бэлэн болгох хүртэл хийгдэх үйл ажиллагаа буюу эвдэрсэн газрыг нийтийн хэрэгцээнд

тодорхой зориулалтаар ашиглахад бэлэн болгох нөхөн сэргээлтийн анхан шатны үйл ажиллагаа юм.

- 1.1 Техникийн нөхөн сэргээлтийг олборлолтын ажилтай зэрэгцүүлэн хийнэ.
- 1.2 Техникийн нөхөн сэргээлтийг машин, техник хэрэгслийг ашиглан хийж болно.
- 1.3 Тухайн газрыг ашигт малтмалыг олборлосны дараа ашиглах зориулалт болон анхны хэлбэр байдалд нь үндэслэж нөхөн сэргээлтийг хийнэ.
- 1.4 Эвдэрсэн газрын нөхөн сэргээлтийн ажлыг MNS 5915 : 2008 стандартын техникийн ерөнхий шаардлагын 3.2-р хүснэгтийн тусгай зориулалтын бус хэсгийн ангилал, чиглэлийг баримталж гүйцэтгэнэ.

Хүснэгт 3.2

	Нөхөн сэргээх чиглэл	Нөхөн сэргээсэн газрыг ашиглах хэлбэр
	Хөдөө аж ахуйн чиглэл	Бэлчээр, хадлан, тариалангийн талбай
	Ойн аж ахуйн чиглэл	Аж ахуйн зориулалтай ба хамгаалалтын зурвас үүсгэх, ойжуулалт үрсэлгээний талбай
	Усны аж ахуй	Ахуйн ба үйлдвэрлэлийн ус хангамж

- 1.5 Нөхөн сэргээх талбайн хог хаягдал, гялгар уут болон байгальд хортой материалуудыг цэвэрлэнэ.
- 1.6 Хөрс хуулалтын үед гаргасан том чулуулгуудыг ашиглаж дууссан талбайн ёроол хэсэгт дэвсэнэ.
- 1.7 Үүний дээрээс хоосон чулуулаг болон элс хайрга, үржил шимгүй хөрсийг хийж эвдэрсэн газар, олборлолтын амыг дүүргэж хучилт хийнэ.
- 1.8 Хөрс хуулалтын үед гаргасан үржил шимт хөрсөөр хамгийн дээд давхарга үүсгэн хучилт хийнэ.
- 1.9 Хучилт хийсний дараа тухайн газрыг үерийн болон борооны усанд урсаж дахин эвдэгдэхээс хамгаалсан ус урсах суваг хийж өгнө.
- 1.10 Үүсмэл гадаргууг тодорхой зориулалтаар ашиглахад тохиромжтой болгож, засч тэгшилсэн байна.
- 1.11 Техникийн нөхөн сэргээлт хийсэн газрын шинж чанар, цаашид ашиглах зориулалтаас хамааран тэгшилгээг нэлэнхүйд нь буюу хэсэгчилсэн гэсэн 2 янзаар хийнэ.

- 1.12 Нэлэнхүйд нь хийх тэгшилгээгээр мод болон үр суулгах нөхцөлийг харгалзан үзэж зөвшөөрөгдөх хэмжээний хэвгий буюу 18⁰-аас бага налуу үүсгэн газрын гадаргыг тэгшилнэ.
- 1.13 Хэсэгчилсэн тэгшилгээгээр тухайн эвдэрсэн газрын гадаргуугийн шинж чанарын онцлогийг хадгалах замаар засч тэгшилнэ.
- 1.14 Нарийвчилсан тэгшилгээг нөхөн сэргээлт хийсэн газрын чулуулгийн суулт явагдсаны дараа хийж тэгшилнэ.

2. Хучилт хийж хөрсийг сайжруулах

Хучилт хийх хөрс нь нөхөн сэргээлт хийсэн газарт ургамал ургах тохиромжтой нөхцөлийг бүрдүүлсэн байна. Ойт хээрийн бүсэд ургамалын нөмрөг сайтай байдаг учир тэнд хуримтлагдсан шимт хөрс ихтэй, ус чийгийн хангамж сайн, үржил шимтийн үе давхарга зуузаан байдаг бол говь цөлийн бүсэд тархсан хөрс нь гадаргадаа ургамлын нөмрөг туйлын ядуу, ихэвчлэн элс хайрга болон сайр чулуун хучаастай, үржил шимт хөрс муу байдаг байна. Иймээс хучилт хийх хөрсийг сайжруулахдаа бууц, сүрэл, ногоон бордоо зэргийг ашиглах хэрэгтэй.

- 1.1 Биологийн нөхөн сэргээлт хийх талбайг үржил шимт хар шороон хөрсөөр 30—50 см -ийн зузаантай хучилт хийж өгнө.
- 1.2 Хучилт хийсэн хөрсийн чанарыг сайжруулах зорилгоор бордоо хийж болно.

3. Биологийн нөхөн сэргээлт

Биологийн нөхөн сэргээлтийн үйл ажиллагааг техникийн нөхөн сэргээлтийн ажил бүрэн дуусч, талбайн хөрс чулуулаг тогтворжиж нягтарсаны дараа хийж гүйцэтгэнэ. Биологийн нөхөн сэргээлт нь дараах үндсэн шаардлагыг хангасан байна.

- 1.1 Биологийн нөхөн сэргээлт хийхдээ ургамлын төрөл зүйлийг бүс нутгийн онцлог, цаг уурын нөхцөлтэй уялдуулан ургамал, суулгацыг тариална.
- 1.2 Ургамал суулгацыг тарихдаа арчилгаа бага шаардагдах олон наст болон нутгийн ургамлуудыг нутагшуулан тариалах хэрэгтэй.
- 1.3 Мод, бут, сөөг болон ургамлын үрийг тарих хугацааг дараах хүснэгтэнд харуулав.

№	Байгалийн бүс	Усалгаагүй бүс	Усалгаатай нөхцөл
1	Уулархаг бүс	6-р сарын 3 дахь 10 хоногт	5-р сарын 3 дахь 10 хоногт
2	Ойт хээр, хээрийн бүс	6-р сарын 2 дахь 10 хоногт	5-р сарын 2 дахь 10 хоногт
3	Гов, цөлийн бүс	5-р сарын 3 дахь 10 хоногт	5-р сарын эхний 10 хоногт

- 1.4 Мод, бут, сөөгийг ширхэгээр тарих боломжтой.
- 1.5 1-2 настай ургамлыг биологийн нөхөн сэргээлтэнд ашиглахыг хориглоно.
- 1.6 Үржил шимт хөрсийг сийрүүлж хог хаягдалыг цэвэрлэн ургамал тарихад бэлэн болгоно.
- 1.7 Бэлэн болгосон хөрсөнд ургамлыг тарихдаа талбайн хэмжээг харгалзан үзэх хэрэгтэй.
- 1.8 Талбай хэмжээ их биш бол ургамалын үрийг цацаж тарих ба салхи багатай үеийг сонгож тариална.
- 1.9 Ургамлын үрийг 2.0-2.5 см-ийн гүнд, мод, бут, сөөг тариалах бол 30-50см-ийн гүнд суулгана.
- 1.10 Ургамал үрийг суулгасны дараагаар ургамлыг бие даан ургах хүртэл нь усалж арчилна.

Б. Эдийн засгийн үр ашиггүйд тооцогдсон орд, илэрлүүд

Эдийн засгийн үр ашиггүйд тооцогдсон орд, илэрлүүд бүхий газарт үйл ажиллагаа явуулах нөхөрлөлүүд хөрс хуулалтыг олборлолтын үйл ажиллагаагаа эхлүүлэхийн өмнө хийх бөгөөд доорхи зааврын дагуу хийнэ. Үүнээс гарсан үржил шимт хөрсийг биологийн нөхөн сэргээлт хийхэд эргүүлэн ашиглана.

4. Хөрс хуулалт ба хоосон чулуулгыг овоолох

Олборлолтын үйл ажиллагаа явуулах талбайд хөрс хуулалтыг хийсний дараа ашигт малтмалыг олборлох ажлыг эхэлнэ.

- 1.1 Олборлолт хийх газрынхаа хөрсний үржил шимт үе давхаргыг тухайн хөрсний шинж чанараас хамаарч үржил шим нь тодорхойгүй хөрсөн давхрага хүртэл хуулж олборлолтын амнаас дор хаяж 5 м-ийн зайд овоолго үүсгэж байрлуулна.

- 1.2 Үүний дараа үржил шим нь тодорхойгүй хөрсний давхаргыг ул чулуун давхаргад хүртэл хуулж үржил шимт хөрсний овоолгоноос зайтай газар тусд нь овоолго үүсгэж байрлуулна.
- 1.3 Овоолгыг үүсгэхдээ суурьт нь том ширхэгтэй материалыг дэвсэж усны шүүрэлт, шингээлтийн нөхцөлийг бүрдүүлэхээс гадна салхины чиглэлийг харгалзан үзэж, урсгал болон хур тунадасны урсац дайрч болзошгүй газарт байрлуулахгүй байх.
- 1.4 Улнаас гарсан том чулуулгуудыг мөн дээрхийн адил овоолго үүсгэж байрлуулна.
- 1.5 Үржил шимт хөрсний хуулалтыг хайргын агууламж өндөртэй, чулуулаг ихтэй хөрс бүхий газарт хийх шаардлагагүй.

Үржил шимт хөрсийг хуулсны дараа олборлолтын үйл ажиллагаа явагдана. Олборлолтын үйл ажиллагаа бүрэн гүйцэт хийсний дараа техникийн болон биологийн нөхөн сэргээлтийг хийнэ. Түүнийг хийхдээ “Ашиглалтын болон технологийн хаягдлаар бий болсон үүсмэл орд”-ын нөхөн сэргээлт хийх зааврын дагуу хийж гүйцэтгэнэ.

Далд уурхайн нөхөн сэргээлт:

Засгийн газрын 308 дугаар тогтоолоор батлагдсан “Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам”-ын 5.5-д заасны дагуу нөхөрлөл нь тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй байгуулсан гурвалсан гэрээний дагуу далд уурхайг ашиглах бөгөөд талбайн нөхөн сэргээлтийг тусгай зөвшөөрөл эзэмшигч хариуцана.

Ашигласан талбайг хүлээлгэн өгөх (Уурхайн хаалт) нөхөн сэргээлтийг дүгнэх

Нөхөрлөл талбайг буцаан хүлээлгэж өгөхийн өмнө тухайн талбайд техникийн болон биологийн нөхөн сэргээлтийн ажлыг зааврын дагуу хийж байгаль орчны хяналтын улсын байцаагчийн дүгнэлт гаргуулан, сум дүүргийн Засаг даргын томилсон комисст хүлээлгэн өгнө.

АМГ-ын даргын 2011 оны 153
тушаалын тавдугаар хавсралт

Бичил уурхайн аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм

Нэг. Ерөнхий зүйл

1. Энэ дүрмийг Монгол Улсын нутаг дэвсгэр дээр бичил ил уурхайгаар ашигт малтмал олборлох үйл ажиллагаа явуулж буй нөхөрлөл, түүний ахлагч, гишүүд дагаж мөрдөнө.

2. Энэ дүрмээр зохицуулагдахгүй бичил ил уурхайн аюулгүй ажиллагаанд “Ил уурхайн аюулгүй ажиллагааны дүрэм”-ийг мөрдөж ажиллана.

3. Энэ дүрмээр зохицуулагдахгүй бичил далд уурхайн аюулгүй ажиллагаанд “Хүдэр, хүдрийн бус, шороон ордыг далд аргаар олборлох аюулгүй ажиллагааны дүрэм”, “Нүүрсний далд уурхайн аюулгүй ажиллагааны дүрэм”-ийг мөрдөж ажиллах ба аюулгүй ажиллагааг тусгай зөвшөөрөл эзэмшигч хангуулж ажиллана.

4. Бичил уурхайгаар олборлосон хүдрийн боловсруулах, баяжуулах цехэд “Ашигт малтмалыг баяжуулах, ялгах, бутлах ба хүдэр, баяжмалыг бөөнцөглөх аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм” -ийг мөрдөж ажиллана.

5. Бичил уурхайн тэсэлгээний ажлыг Монгол Улсын холбогдох хууль, тогтоомжид заасны дагуу тэсэлгээний ажил явуулах тусгай зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгжээр гүйцэтгүүлэх ба “Тэсэлгээний аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм” -ийг мөрдлөг болгон ажиллана. Нөхөрлөл, хувь хүн бие даан тэсэлгээний ажил явуулахыг хориглоно.

Хоёр. Нийтлэг шаардлага

6. Нөхөрлөлийн ахлагч (цаашид “ахлагч” гэх) нь далд уурхай, баяжуулах цех, тэсэлгээнээс бусад бичил уурхайд ажиллаж байгаа нөхөрлөлийн гишүүд (цаашид “гишүүн” гэх)-ийн хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн асуудлыг хариуцан ажиллана. Үүнд:

6.1. Бичил уурхайн ажилтан бүрт бичил уурхайн аюулгүй ажиллагааг хангаж ажиллах талаар хүлээх үүрэг, хариуцлагыг тайлбарлан таниулж, ажлын байрны урьдчилсан зааварчилгаа өгнө.

6.2. Ажилтанд ажлын байрны урьдчилсан зааварчилгаа өгсний дараа анхан шатны зааварчилгаа өгч ажлыг эхлүүлнэ.

6.3. Улиралд нэгээс доошгүй удаа ажлын байрны давтан зааварчилгаа өгнө.

6.4. Ажлын байрны урьдчилсан, анхан шатны болон давтан зааварчилгаа авсан ажилтныг журналд бүртгэж гарын үсэг зуруулна.

6.5. Ажил эхлэхийн өмнө ажлын байр, ажилтнуудын эрүүл мэнд, аюулгүй үйл ажиллагаа явуулахад шаардлагатай ажлын тусгай хувцас (малгай, бээлий гэх мэт), хамгаалалтын бүс, нэг бүрийн хамгаалах хэрэгсэл зөв өмссөн эсэх, ажил гүйцэтгэхэд шаардагдах багаж хэрэгсэл аюулгүй ажиллагааны шаардлага хангасан эсэхийг шалгана.

6.6. Ажлын байранд хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн зөрчил илэрсэн тохиолдолд түүнийг арилгасны дараа ажил эхлүүлнэ.

6.7. Өвчтэй буюу эрүүл мэндийн байдлаар ажиллах чадваргүй байгаа ажилтныг тухайн өдөр ажилд гаргахыг хориглоно.

6.8. Ажилтнуудыг эрүүл мэндийн үзлэгт жилд нэгээс доошгүй удаа хамруулна.

6.9. Гэнэтийн ослын үед анхан шатны тусламж үзүүлэхэд шаардлагатай хэрэгслийг бэлэн байлгана.

6.10. Бичил уурхайд осол гарсан тохиолдолд “Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчин хурц хордлогыг судлан бүртгэх дүрэм”-ийн дагуу ослыг судлан бүртгэж, сум, дүүргийн Засаг даргад тухай бүр мэдэгдэнэ.

6.11. Тухайн жилд гарсан ослын талаарх тоо баримтыг дараа жилийн нэгдүгээр сард багтаан сум, дүүргийн Засаг даргад хүргүүлнэ.

6.12. Уурхайд гарсан ослын шалтгааныг судалж цаашид ийм төрлийн осол гарахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

6.13. Олборлолт явуулсан газарт хүн, мал, техник унаж гэмтэхээс хамгаалсан хаалт, далан байгуулна. Тэсэлгээний цооног, ус зайлуулах суваг, шуудуу, малталт, усан сан зэрэгт таглаа, хаалт, хамгаалалт хийнэ.

6.14. Уурхайн бүсэд үер, усны аюулаас урьдчилан сэргийлэх ус зайлуулах суваг, шуудуу гаргасан байна.

6.15. Уурхайн бүсэд бичил уурхайн аюулгүй ажиллагааны анхааруулах самбар байрлуулна.

7. Нөхөрлөлийн гишүүн (ажилтан) нь:

7.1. Бичил уурхайн аюулгүй ажиллагааны дүрэм, зааврыг судалж, ахлагчийн өгсөн аюулгүй ажиллагааны зааварчилгааны дагуу ажиллана.

7.2. Ажил эхлэхийн өмнө ажлын байр, тоног төхөөрөмжийн аюулгүй байдлыг шалгаж зөрчил илэрвэл энэ тухай ахлагчид мэдэгдэж, түүнийг арилгах арга хэмжээ авна.

7.3. Шаардлагатай ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслийг иж бүрэн зөв хэрэглэнэ.

7.4. Гэнэтийн осол аваар гарах, амь нас, эрүүл мэндэд сөрөг, аюултай нөхцөл байдал бий болсон тохиолдолд ажлаа зогсоож бусад ажилтан болон ахлагчид яаралтай мэдэгдэж, осол аваарыг устгах шуурхай арга хэмжээ авна. Шаардлагатай тохиолдолд аюулын бүсийг орхино.

7.5. Олборлолтын явцад осол, аваар гарах аюултай нөхцөл үүсэх шинж тэмдэг илэрвэл яаралтай зогсоож энэ тухай ахлагчид мэдэгдэж аюулыг шуурхай арилгах арга хэмжээ авна.

7.6. Ажилтан бүр эрүүл мэндийн урьдчилсан үзлэгт хамрагдсан байна.

7.7. Тоног төхөөрөмжийн ажлын бүс, догол, мөрөгцөгийн доор, тээврийн хэрэгслийн зам дээр амарч, унтахыг хориглоно.

Гурав. Бичил ил уурхай

8. Бичил ил уурхайд хэт өндөр, огцом босоо мөрөгцөг (хажуу хана) гаргахыг хориглох бөгөөд ашиглалтын нөхцөл, аюулгүй байдлыг хангах зорилгоор ажлын хэд хэдэн догол гаргаж ашиглалт явуулна.

9. Мөрөгцөгийн өндрийг чулуулгийн шинж чанар, оршиц, тогтоцын байдлыг үндэслэн 2.5 м-ээс илүүгүй байна.

10. Ажлын мөрөгцөгийн налуугийн өнцөг зөөлөн тогтвортой чулуулагт 50 градусаас ихгүй, хадархаг чулуулагт 80 градусаас ихгүй байна.

11. Олборлолтын талбайн өргөн нь хүн, техник ажиллахад чөлөөтэй, аюулгүй байдлыг хангасан байх ба 2м-ээс багагүй байна.

12. Ажлын мөрөгцөгт саравч гаргаж ухахыг хориглоно.

13. Дээд, доод доголоуд дахь ажлын мөрөгцгүүд нэг босоо шугам дээр давхцаж болохгүй.

14. Уурхайн нэг доголоос нөгөөд шилжихэд 0.8 м-ээс багагүй өргөнтэй бат бөх шат ашиглах эсхүл 45 хэмээс ихгүй налуутай гарц гаргасан байна.

15. Уурхайн ашиглагдсан хоосон орон зайг буцааж булах, хашаа босгох, анхааруулах тэмдэг тавих замаар аюулгүй болгоно.

Дөрөв.Бичил далд уурхай

16. Ашиглах гэж байгаа ордын шинж чанар, байрлал, чулуулгийн хатуулгаас хамааран бичил далд уурхайд босоо, налуу, хэвтээ ам гаргана. Уурхайн амыг гаргахдаа аль болох бат бөх, ан цавгүй, хатуу чулуулагтай, нуралт, гулсалт үүсэхээргүй, хөрсний болон үерийн ус орохооргүй газрыг сонгоно.

17. Уурхайгаас ажилтнуудыг гаргахад зориулсан, ашигт малтмалын биед хүрч хоорондоо холбогдсон хоёроос доошгүй гарц гаргасны дараа олборлолт явуулна. Уурхайгаас газрын гадаргуу дээр гарах нэг амтайгаар олборлолт явуулахыг хориглоно.

18. Уурхайн аманд нуралт, гулсалтаас хамгаалсан бэхэлгээ хийнэ. Бэхэлгээг шуудайлж савласан элс, шороо, чулуу, мод, бетоноор хийнэ.

19. Уурхайн налуу амны налуугийн өнцөг нь тогтвортой хатуу чулуулагтай газарт 45 градусаас, хатуулаг багатай буюу тогтворгүй чулуулагтай газарт бол 10 градусаас илүүгүй байна.

20. Уурхайн босоо 2 амны хоорондын зай 10 м-ээс багагүй байна.

21. Уурхайн босоо, налуу амсарыг зориулалтын материалаар хашиж бэхлэх ба амыг тойрсон хамгаалалт хүрээ хийж “Аюултай” гэсэн үг бүхий анхааруулах тэмдэг тавина.

22. Уурхайн малталтын өндөр нь 1.5 м, өргөн нь 1.2 м-ээс багагүй байна.

23. Уурхайн малталтаар ажилтан явахад зориулсан хэсгийн налуу нь 15 градусаас ихгүй байх ба үүнээс их бол бэхэлгээнд бариул, гишгүүр, шат зэргийг хөдөлгөөнгүй бэхлэн тоноглоно.

24. Бичил далд уурхайн гүн нь 5 м ба түүнээс их байвал дамарт өргүүр ашиглана. Газар доор хүмүүс ажиллаж байгаа үед дамарт өргүүрийг ажиллуулах хүнгүй орхих, түгжээгүй дамарт өргүүр ашиглахыг хориглоно.

25. Уурхайн гүнд цэвдэг, тогтвортой хатуу чулуулаг дундуур нэвтэрсэн хэвтээ ба налуу малталтыг бэхлэхгүй байж болох бөгөөд нурал үүсэхүйц хэт их орон зай гаргаж малтахыг хориглоно.

26. Уурхайн гүнд хатуулаг багатай, тогтворгүй чулуулаг дундуур нэвтэрсэн хэвтээ ба налуу малталыг дараах байдлаар бэхэлнэ:

26.1. Хүдрийн биет, хоосон чулуулгаар багана үүсгэж үлдээх;

26.2. Мод, төмрөөр тулгуур, багана босгох;

26.4. Элс, шороог шуудайд савлаж өрсөн багана босгох;

26.5. Мод, төмөр рам зангидаж чулуугаар дүүргэсэн багана босгох;

26.6. Малталтаа нийтэд нь мод, төмрөөр бэхлэх.

27. Уурхайн малталтын аюулгүй байдлыг ажлын явцад, тэсэлгээний ажлын дараа шалгаж аюултай байдал илэрвэл ажлын ахлагч нарт яаралтай мэдэгдэж уг аюулыг яаралтай арилгах арга хэмжээ авна.

28. Ашиглахгүй болсон, цаашид хүндрэл бэрхшээл учруулж болзошгүй далд малталтыг устгаж аюулгүй болгох арга хэмжээ авна.

29. Уурхайн гүний малталт 10 м-ээс урт байвал байгалийн болон зохиомол агааржуулалтын систем ашиглана.

30. Байгалийн агааржуулалтыг зөв хийхийн тулд уурхайн амууд газрын гадаргуу дээр 2 өөр түвшинд байх шаардлагатай. Энэ шаардлагыг хангах боломжгүй бол энгийн хоолой (яндан) гаргаж агааржуулна.

31. Уурхайн малталтын нийт урт нь 20 м, түүнээс их байвал зохиомол агааржуулалт хийнэ. Зохиомол агааржуулалтанд сэнс ашиглана. Агаар дамжуулахад агаар нэвтрүүлдэггүй гялгар материалаар хийсэн хоолой ашиглана.

Тав. Овоолгын ажил

32. Овоолго байгуулах газрыг сонгохдоо байгаль орчинд нөлөөлөх байдал, аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн шаардлагыг харгалзан үзнэ. Овоолгын доод хормой нь малталтын амсараас 5 м-ээс багагүй зайтай байх бөгөөд овоолгын хажуугийн налуу нь нурах налууугийн өнцгөөс ихгүй байна.

33. Ашигт малтмалын нөөц бүхий газарт овоолго байгуулахыг хориглоно.

Зургаа. Бичил уурхайн тоног төхөөрөмж

34. Бичил уурхайн багаж хэрэгсэл, тоног төхөөрөмж нь уурхайн зориулалтын хийцтэй, хориг түгжээ, хаалт хамгаалалттай байна.

35. Хийн алх, өрмийг өөр газар шилжүүлэн ажиллуулахын өмнө төхөөрөмжийг унтрааж хоолойноос хийг гаргасан байна.

36. Гараар барьж ажиллуулдаг цахилгаан багаж хэрэгсэл нь цахилгаан гүйдлийн аюулаас хамгаалах давхар тусгаарлагчтай байна.

37. Хий тоосны тэсрэх аюултай (нүүрсний) уурхайд очны аюулгүй байдлыг хангасан цахилгаан багаж, хэрэгсэл, тоног төхөөрөмж ашиглана.

38. Бичил далд уурхайн гүнд дотоод шаталт хөдөлгүүр бүхий техник, тоног төхөөрөмж ашиглахыг хориглоно.

39. Уурхайд ашиглаж байгаа дамарт өргүүрийн олсыг тогтмол шалгаж, ямар нэг зөрчил илэрсэн тохиолдолд солих шаардлагатай.

40. Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох үйл ажиллагаанд 500 см³-ээс дээш багтаамжтай дотоод шаталтат хөдөлгүүр бүхий механизм ашиглахыг хориглоно.

Долоо. Хөдөлмөрийн эрүүл ахуй

Бичил уурхайн тоосжилт, хорт хий, бодисын нөлөөнөөс хамгаалах

41. Бичил уурхай эрхлэгч бүр ам, хамрын хаалт, хушуувч, баг (респиратор) зэрэг тоосноос хамгаалах хэрэгсэл байнга хэрэглэнэ.

42. Уурхайн тоосжилт ихтэй хэсэгт зохиомол агааржуулалт хийнэ.

43. Бичил уурхайн ажлын бүсийн агаарын бүтэц, найрлагыг агаар хэмжигч багаж эсхүл дөлний хамгаалалттай дэн ашиглаж шалгана. Бичил уурхайн ажлын байрны агаар дахь тоосны зөвшөөрөгдөх дээд хэмжээг 1-р хүснэгтэд харуулав.

1-р хүснэгт

№	Тоосны шинж чанар	Зөвшөөрөгдөх дээд Хэмжээ, мг/м ³
1	Цахиурын давхар ислийн агуулга 70%-аас их (кварц, динас г.м.)	1
2	Цахиурын давхар ислийн агуулга 10-70% (гранит, шамот, слюда г.м.)	2
3	Цахиурын давхар ислийн агуулга 2-10% (шатамхай занар, зэс сульфидийн хүдэр, нүүрс, шавар г.м.)	4
4	Цахиурын давхар ислийн агуулга 2%-аас бага (г.м.)	10

44. Уурхайн ажлын бүсийн агаарт хүчилтөрөгч (O₂) 19.5 %-аас багагүй, нүүрсхүчлийн хий (CO₂) 0.5 %-аас ихгүй байна.

45. Уурхайд тэсэлгээ хийлгэсний дараа зохиомол агааржуулалт хийж хортой хий, бодис, тоосыг зайлуулж агаарын найрлагыг хэмжинэ. Бичил уурхайн ажлын бүсийн агаар дахь зарим хортой хий, бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээг 2-р хүснэгтээр харуулав.

2-р хүснэгт

№	Хортой хий, бодис	Эзлэхүүн, %	Концентраци, г/м ³
1	Азотын исэлүүд • N_2O_5-д шилжүүлснээр • NO-т шилжүүлснээр	0.0001 0.0002	5 2
2	Нүүрстөрөгчийн дутуу исэл CO	0.0016	20
3	Хүхэрт устөрөгч H_2S	0.00066	10
4	Хүхэрлэг ангидрид SO_2	0.00035	10
5	Акролеин $CH_2=CHCHO$	0.00009	0.2
6	Формальдегид CH_2O	0.00004	0.5
7	Бензипрен 3.4	-	0.00015

46. Тэсэлгээний ажлын дараа болон ажлын байрыг халаахаар галлагаа хийсний дараа агааржуулалт хийж, агаарын найрлага дахь бодисын хэмжээ зөвшөөрөгдөх хэмжээнд болох хүртэл уурхайд орохыг хориглоно. Хортой хий, бодисоор бохирдсон агаартай орчинд зайлшгүй орох шаардлага гарвал хорт хийн хамгаалах баг (респиратор) хэрэглэнэ. Тоосноос хамгаалах хэрэгсэл нь хортой хий, бодисоос хамгаалахгүй.

47. Хэрэв ажилтан агаар дутагдах, амьсгалахад хэцүү болох, толгой эргэх, толгой өвдөх, дотор муухай болох зэргээр ямар нэг химийн хорт бодис ялгарч байгааг мэдэрвэл ажлын байрыг яаралтай орхин гарч шаардлагатай агааржуулалт хийнэ.

48. Бичил уурхайд химийн хорт болон аюултай бодис ашиглахыг хориглоно.

Шуугиан, доргионы хортой нөлөөнөөс хамгаалах

49. Бичил уурхайн ажлын бүсийн шуугианы ерөнхий түвшин 85 дБА-аас ихгүй байх ёстой бөгөөд зөвшөөрөгдөх хэмжээнээс их шуугианд сонсголын эрхтэн хамгаалах чихний бөглөө, чихэвч хэрэглэнэ.

50. Бичил уурхайд чулуулгийг цохиж буулгах, бутлах, хийн алх, өрөм ашиглах үед зөөллөгч жийргэвчтэй бээлий, хамгаалалтын нүдний шил, доргион тусгаарлагч, зөөлөвчтэй гутал өмсөнө.

Бичил уурхайчдын амьдрах суурьшлын бүс, хог хаягдлын менежмент

51. Бичил уурхайчид олборлолтын талбайн гадна орон нутгийн засаг захиргаанаас тогтоож өгсөн суурьшлын бүсэд амьдарна.

52. Бичил уурхайчид орон нутгийн засаг захиргаанаас тогтоосон цэгт ариун цэврийн шаардлага хангасан хог хаягдлын цэг болон бие засах газар барьж байгуулна.

Бичил уурхайн гэрэлтүүлэг

53. Далд уурхайн харанхуй бүсэд ажиллах үед бичил уурхай эрхлэгч бүр зориулалтын нэг бүрийн гэрэлтүүлэгчийг хэрэглэнэ. Нэг бүрийн гэрэлтүүлэгч нь 8 цагаас доошгүй хугацаагаар тасралтгүй, хэвийн ажиллах хүчин чадалтай байна.

54. Далд уурхайд нэг бүрийн гэрэлтүүлэгчгүй орох, уурхайн малталтанд гэрлээ асаахгүй ажиллах, явах, амрахыг хориглоно.

Найм. Дүрэм зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага

55. Энэ дүрмийг зөрчсөн буруутай этгээдэд холбогдох хууль, тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

----- о О о -----

Бичил уурхайн аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгөх аргачлал

Нэг. Ерөнхий зүйл

1.1. Бичил уурхайд хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн ажлыг зохион байгуулах, ажлын байрны эрүүл ахуйн шаардлагыг хангуулах, аюулгүй ажиллагааны арга барилд сургах, зааварчилгааа өгөх болон хяналт тавих ажилд “Бичил уурхайн аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм”-ийг мөрдөн ажиллана.

1.2. Ажлын байрны аюулгүй ажиллагааны урьчилсан, анхан шатны, давтан зааварчилгын агуулгыг бичил уурхайн нөхөрлөлийн ахлагч боловсруулна.

1.3. Ажлын байрны аюулгүй ажиллагааны урьдчилсан, анхан шатны, давтан зааварчилгаа өгсний дараа уг зааварчилгыг авсан ажилтанаас мэдлэгийн шалгалт авч тусгай журналд огноо, агуулга, шалгалт өгсөн ба авсан хүний нэрийг бичиж гарын үсэг зуруулна.

1.4. Зааварчилгаа аваагүй ажилтаныг бичил уурхайд ажиллуулахыг хориглоно.

1.5. Тусгай журналыг нөхөрлөл бичил уурхайн үйл ажиллагаа явуулж буй бүх хугацааны туршид хадгалана.

Хоёр. Аюулгүй ажиллагааны урьдчилсан зааварчилгаа өгөх

2.1. Нөхөрлөлийн шинэ гишүүнд түүний ажилласан жил, ажлын туршлагыг харгалзахгүйгээр **урьдчилсан зааварчилгаа** өгнө.

2.2. Урьдчилсан зааварчилгын **агуулга** нь дараах асуудлуудаас бүрдэнэ:

1.1.1. Бичил уурхайн аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм;

1.1.2. Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн бусад дүрэм, заавар;

1.1.3. Тухайн бичил уурхайн өвөрмөц онцлог, дотоод журам;

1.1.4. Осолдогчдод үзүүлэх анхны тусламж.

Гурав. Аюулгүй ажиллагааны анхан шатны зааварчилгаа өгөх

3.1. Бичил уурхайн нөхөрлөлд элсэж урьдчилсан зааварчилгаа авсан ажилтанд мөн түүнчлэн тухайн ажилтны ажилладаг хэсэг, ажлын дамжлага өөрчлөгдөх тухай бүр **ажлын байрны анхан шатны зааварчилгаа** өгнө.

3.2. Ажлын байрны анхан шатны зааварчилгын **агуулга** нь дараах асуудлуудаас бүрдэнэ:

- 1.1.1. Тухайн ажлыг гүйцэтгэх ажлын онцлог;
- 1.1.2. Тоног төхөөрөмж, багаж, хэрэгсэл ашиглалт;
- 1.1.3. Ажлын явцад үүсэж болох сөрөг хүчин зүйл, түүнээс хамгаалах хэрэгсэл;
- 1.1.4. Осолдогчдод үзүүлэх анхны тусламж.

3.3. Ажлын байрны анхан шатны зааварчилгыг тухайн ажлын байрыг хариуцаж ажиллах ахлагч, эсвэл бичил уурхайн нөхөрлөлийн ахлагч биечлэн өгнө.

Дөрөв. Аюулгүй ажиллагааны давтан зааварчилгаа өгөх

4.1. Бичил уурхайн ажилтанд өмнө олгосон мэдлэгийг бататгах, баяжуулах зорилгоор аюулгүй ажиллагааны урьдчилсан, анхан шатны зааврын агуулгаар **давтан зааварчилгаа** өгнө.

4.2. Давтан зааварчилгаа нь гурван хэлбэртэй байна. Үүнд:

- 4.2.1. Ээлжит давтан зааварчилгаа;
- 4.2.2. Ээлжит бус давтан зааварчилгаа;
- 4.2.3. Ажлын байран дахь өдөр тутмын давтан зааварчилгаа.

4.3. Бичил уурхайн бүх ажилтанд улиралд нэгээс доошгүй удаа **ээлжит давтан зааварчилгаа** өгнө. Ээлжит давтан зааварчилгаа аваагүй ажилтанг ажиллуулахыг хориглоно.

4.4. Шинэ тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл нэвтрүүлэх, хөдөлмөрийн нөхцөл өөрчлөгдөх, бичил уурхайн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн дүрэм, заавар шинэчлэгдэж өөрчлөгдөх үед давтан зааварчилгаа өгөх ээлжит хугацаанаас нь өмнө **ээлжит бус давтан зааварчилгаа** өгнө.

4.5. Бичил уурхайн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн дүрэм, зааврыг ноцтой зөрчсөн бичил уурхайн ажилтан нарт, мөн нэг сараас илүү хугацаагаар ажлаа гүйцэтгээгүй ажилтанд **ээлжит бус давтан зааварчилгаа** өгнө.

АМГ-ын даргын 2011 оны 153 тушаалын
зургаадугаар хавсралт

БИЧИЛ УУРХАЙ ЭРХЛЭГЧДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААРХИ МЭДЭЭЛЛИЙН МАЯГТ

Хүснэгт 1

Аймаг	Сум	Газрын нэр / тусгай зөвшөөрлийн дугаар		3	
		Солбицол		4	
Ашиглаж байгаа талбайн хэмжээ (га)		Ашигт малтмалын төрөл		6	
Ашиглалт	Ил	Далд		7	
				8	
Нөхөрлөл	Нөхөрлөлийн нэр			9	
	Гэрээ байгуулж, олборлолт эхэлсэн огноо			10	
	Гшүүдийн тоо			11	
Үүнээс		эр	эм	12	
				13	
	байнга	улирлын чанартай		14	
Үүнээс		орон нутгийн иргэд		15	
				16	
	Бүртгэлийг үйл ажиллагаа явуулж байгаа иргэдийн тоо			17	
Үүнээс		Насанд хүрсэн хүмүүс		18	
		18 хүртэлх насны хүүхдүүд		19	
Олборлолт явуулж эхэлснээс хойш эвдрэлд орсон талбай (га)				20	
Нөхөн сэргээлт хийсэн талбай (га)				21	
Бичил уурхай эрхлэгчдийн осолч мэдээ				22	

БИЧИЛ УУРХАЙ ЭРХЛЭГЧ ИРГЭДИЙН СУДАЛГАА

Хүснэгт 2

Аймаг	Сум	Нөхөрлөлийн нэр	Бү-г нэг гэр бүлээс хэдэн хүн эрхэлдэг										БҮЭ-ийн сарын дундаж орлого			БҮЭ-ийн иргэний ам бүлийн дундаж тоо			БҮЭ-дийн боловсролын түвшин (%)			БҮЭ-дийн мэргэжил			БҮЭ-ийн нас		БҮЭ-дийн даатгал	
			4	3	2	1	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	17	18	19	ЭМ-д хамрагдсан хүний тоо	НД-д хамрагдсан хүний тоо					
1	2				ашит малтай олборлон олж байгаа сарын дундаж орлого	бусад сарын дундаж орлого	өрхийн гишүүдийн бусад орлого	насанд хүрсэн	насанд хүрээгүй	нийт	дээд	дунд	бага	Геологи, уул уурхайн мэргэжилтэй	Бусад мэргэжилтэй	Мэргэжлгүй	18 хүртэлх насны хүүхдүүд	Насанд хүрсэн хүн	НД-д хамрагдсан хүний тоо	ЭМ-д хамрагдсан хүний тоо								

БИЧИЛ УУРХАЙН ТАЛБАЙН СУДАЛГАА

БИЧИЛ УУРХАЙН ХОЛБОГДОЛТОЙ ХУУЛЬ, ТОГТООМЖ

Хүснэгт 3

Аймаг	Сум	Ашиглаж байгаа газрын нэр	Ашиглаж байгаа талбайн хэмжээ	Нөхөн сэргээлт хийсэн талбай (га)	Цаашид бичил уурхайн зориулалтаар ашиглах боломжтой талбайн солбицол
1	2	3	4	5	6

АМГ-ын даргын 2011 оны
153 тушаалын долоодугаар хавсралт

Батлав: Зөвшөөрөв:

"....." нөхөрлөлийн /сум, дүүргийн/
ахлагч /..... / Засаг дарга /...../

.....
(Аймаг, сум, байршил, ордын нэр)

**Бичил уурхайн байгаль орчныг хамгаалах, нөхөн
сэргээх болон хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны
хүрээнд авах арга хэмжээний**

.....
(төлөвлөгөө / тайлан)

ТАНИЛЦСАН:

БО-ны улсын байцаагч

Бичил уурхайн мэргэжилтэн

БОЛОВСРУУЛСАН:

1.....

2.....

.... оны сар..... өдөр

..... **БИЧИЛ УУРХАЙН /НӨХӨРЛӨЛИЙН/
ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ**

Хүснэгт1

№	Үзүүлэлтүүд		
1	Нөхөрлөлийн нэр		
2	Ордын нэр		
3	Бичил уурхайн	Аймаг/Хот	
4	байршил	Сум/Дүүрэг	
5	Ашигт малтмалын төрөл		
6	Нөхөрлөлийн хаяг	Аймаг/Хот	
7		Сум/Дүүрэг	
8		Баг/Хороо	
9		Гудамж/Байр	
10	Ахлагчийн хаяг	Утас	
11		Гар утас	
12		Электрон шуудан	
13		Нэр	
14	Ахлагчийн хаяг	Утас	
15		Гар утас	
16		Электрон шуудан	
17	Ашиглах хугацаа /нэг жил хүртэл/		
18	Хүчин чадал /техник, тоног төхөөрөмжийн жагсаалт/		

..... **БИЧИЛ УУРХАЙН /НӨХӨРЛӨЛИЙН/ 20... ОНЫ
БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ, НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН МЭДЭЭ**

Хүснэгт2

№	Үзүүлэлтүүд	Төлөвлөгөө		Гүйцэтгэл	
		га	м³	га	м³
1.	Хэмжих нэгж				
2.	Бичил уурхайд хамрагдах талбай				
Ү	а/. 20... оны нөхөн сэргээлт хийх талбай				
Ү	б/. Дотоод овоолгоор				
Н	в/ Техникийн нөхөн сэргээлт				
Э	г/. Шимт хөрсний нөхөн сэргээлт				
Э	д/ Биологийн нөхөн сэргээлт				
С	е/. Зарцуулагдах хөрөнгийн хэмжээ /төг/				
3.	Эвдрэлд оруулсан талбайн булангийн цэгийн солбицол				
4.	Нөхөн сэргээлт хийсэн талбайн булангийн цэгийн солбицол				

**..... БИЧИЛ УУРХАЙН /НӨХӨРЛӨЛИЙН/ УЛС,
ОРОН НУТГИЙН ТӨСӨВТ ТАТВАР, ЭРҮҮЛ МЭНД, НИЙГМИЙН
ДААТГАЛЫН ШИМТГЭЛИЙН ОРЛОГО ТӨЛӨЛТИЙН МЭДЭЭ**

Хүснэгт3

№	Татварын нэр	Хаанахын төсөвт төлөх (улс, аймаг, сум)	Хэмжих нэгж	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
1.	Нийгмийн даатгалын шимтгэл		мян.төг		
2.	Эрүүл мэндийн даатгалын шимтгэл		мян.төг		
3.	Хүн амын орлогын албан татвар		мян.төг		
4.	Бусад		мян.төг		
5.	Нийт улсын төсөвт оруулсан орлого		мян.төг		

Үзүүлэлт гаргасан:

Хүлээн авсан:

Ахлагч

БУ хариуцсан мэргэжилтэн.....

БО-ны улсын байцаагч.....

.... оны сар..... өдөр

..... **БИЧИЛ УУРХАЙН /НӨХӨРЛӨЛИЙН/ ЭДИЙН
ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД**

Хүснэгт4

№	Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
1.	Борлуулалтын орлого	сая төг.		
2.	Зардал	сая төг.		
4.	Цэвэр ашиг (татварын дараахи)	сая төг.		
5.	Нэгж бүтээгдэхүүний өөрийн өртөг	төг/тн, төг/м³, төг/г		
6.	Нэгж бүтээгдэхүүний борлуулалтын үнэ	Төг/тн		

..... **БИЧИЛ УУРХАЙН /НӨХӨРЛӨЛИЙН/
УУЛЫН АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГҮЙЦЭТГЭЛ**

Хүснэгт5

№	Үзүүлэлт		Хэмжих нэгж	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Гүйцэтгэлийн хувь
1.	Хөрс хуулалт		мян.м³			
2.	Далд уурхай:	үндсэн малталт	уртааш м.			
3.		бэлтгэл малталт	уртааш м.			
4.	Хүдэр олборлолт		мян.м³			
5.	Хүдэр боловсруулалт		мян.м³			
6.	Бүтээгдэхүүн гаргалт		мян.тн, мян.м³, кг			
7.	Дундаж агуулга		г/м³, %			
8.	Металл авалт		%			
9	Бүтээгдэхүүн борлуулалт		мян.тн, мян.м³, кг			

..... **БИЧИЛ УУРХАЙН /НӨХӨРЛӨЛИЙН/
БҮТЭЭГДЭХҮҮН БОРЛУУЛАЛТЫН ТАЙЛАН**

Хүснэгт6

№	Бүтээгдэхүүний төрөл	Бүтээгдэхүүн борлуулсан ба борлуулахаар ачуулсан газар	Хэмжих нэгж	Тоо	Нэгж үнэ, сая төг.	Нийт үнэ, сая төг.
1.						
2.						
3.						
4.						
5.						
Нийт						

Үзүүлэлт гаргасан:

Хүлээн авсан:

Ахлагч

БУ хариуцсан мэргэжилтэн.....

БО-ны улсын байцаагч.....

.... оны сар..... өдөр

..... **БИЧИЛ УУРХАЙН /НӨХӨРЛӨЛИЙН/
ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГАА, ЭРҮҮЛ АХУЙ**

Хүснэгт7

Үзүүлэлт	
Нийт ажилтны тоо:	
Үүнээс: Эмэгтэй	
Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн асуудал эрхэлсэн ахлагчийн нэр	
Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн арга хэмжээнд төлөвлөсөн ба зарцуулсан хөрөнгө, зардал /мян.төг/	
ХАА, ЭА-н сургалтанд хамрагдсан ажилтны тоо	
Ажилтныг жилд хэдэн удаа эрүүл мэндийн үзлэгт хамруулдаг	

**АЖЛЫН ТУСГАЙ ХУВЦАС,
ХАМГААЛАХ ХЭРЭГСЭЛ ОЛГОЛТЫН МЭДЭЭ**

Хүснэгт 8

Үзүүлэлт, төрөл	Эхний улирал	II улирал	III улирал	IV улирал
Ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгсэл олгох жагсаалттай эсэх				
Ажлын тусгай хувцас олговол зохих ажилтны тоо				
Үүнээс: Олгосон				
Хүрэм				
Өмд, цамц				
Бээлий				
Гутал				
Ажлын бусад тусгай хувцас				
Хамгаалах хэрэгсэл олговол зохих ажилтны тоо				
Үүнээс: Олгосон				
Гэрэл				
Дуулга				
Нүдний шил				
Чихэвч				
Амны хаалт				
Хушуувч				
Эмийн сан				
Гал унтраах хэрэгсэл				
Бусад хамгаалах хэрэгсэл болон хэмжигч багаж				

**ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ОСОЛ, ХУРЦ ХОРДЛОГО,
МЭРГЭЖЛЭЭС ШАЛТГААЛСАН ӨВЧНИЙ СУДАЛГАА**

Хүснэгт 9

Үзүүлэлт		
Осолд орсон хүний тоо		
Ослын тоо:		
Ослын хэлбэр	Бүлэг	
	Хөнгөн	
	Хүнд	
Ослын хүчин зүйл, шалтгаан		
Нас баралт		
Хурц хордлогын ба хордогсдын тоо		
Мэргэжлээс шалтгаалсан өвчнөөр өвчлөгсдийн тоо		
Бусад тайлбар болон санал хүсэлт		

Үзүүлэлт гаргасан:

Хүлээн авсан:

Ахлагч

БУ хариуцсан мэргэжилтэн.....

МХ-ын Улсын байцаагч.....

.... оны сар..... өдөр

ХОЛБОО БАРИХ:

Монгол Улс, Улаанбаатар хот
Скай Плаза Бизнес төв
Элчингийн гудамж
Сүхбаатар дүүрэг, 1-р хороо

 +976 11 328848

 +976 11 322415

 info@sam.mn

 www.sam.mn

 ASM Mongolia

 ASM_Mongolia

© Энэхүү гарын авлагыг худалдахыг хориглоно.